# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

2018 он 10 сарын 16 өдөр

Дугаар ЗГ-1/168

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд У.ХҮРЭЛСҮХ

003150

МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 18 он 10 дугаар
сарын 09-ны өдөр

Дугаар ХЭГ/2185

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ЦОЛМОН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацаа товлох тухай

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга Г.ЗАНДАНШАТАР

01139

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, http://www.mof.gov.mn

2018.10.02 № 6/6215

танай ______-ны № XDF/2011-т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР
ТАНАА

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Ч.ХҮРЭЛБААТАР

Ж.Батсайхан

Хянан үзүүлэх баталгаа

0 1549

17.10.18

# МОНГОЛ УЛСЫН
# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
# ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэлд:

"IY.ХЭЛЭЛЦСЭН нь: Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

БАТЛАВ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

# ШУУДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

## Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараахь хууль зүйн болон практик шаардлага байна. Үүнд:

1.Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 он” баримт бичигт тулгуурлан Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын 3.3.8-д “Шуудангийн бүх төрлийн үйлчилгээг Монгол Улсын бүх иргэн, өрх, байгууллага бүрд тэгш, хүртээмжтэй хүргэх боломж бүхий шуудангийн сүлжээг төрийн дэмжлэгтэйгээр хувийн хэвшилд тулгуурлан өргөтгөн хөгжүүлэх” бодлогын чиглэл тусгагдсан.

Энэ бодлогын баримт бичгийн 3.2.1-д Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрх зүйн тогтолцоо, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох замаар салбарын хөгжлийн таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд “Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрх зүйн актыг боловсронгуй болгож, Монгол Улсын хууль болон олон улсын гэрээнд нийцүүлэн шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ” гэж, 3.3.10-т Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ, шаардлагыг хангах мэдээлэл, харилцаа холбооны үндэсний суурь сүлжээ, дэд бүтцийг төрийн дэмжлэг, хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулах зорилтын хүрээнд “Хаягжилтын системийн уялдааг сайжруулж, нэгдмэл болгоно” гэж, 3.4.4-т Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээний төрөл, хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “хаягжилтын нэгдсэн системд суурилсан шуудангийн үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан байна.

2.Монгол Улсын Их Хурал 2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Шуудангийн тухай хуулийг батлснаас хойш уг хуулийг 15 дахь жилдээ дагаж мөрдөж байгаа бөгөөд 2005, 2007, 2015 онд холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан.

Энэ хуулийн хүрээнд шуудангийн салбарт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн байгууллага олноор бий болж, шуудангаар үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, сонголт өсөн нэмэгдэж байна. Хэдийгээр интернэтэд болон цахим сүлжээнд суурилсан шинэ үйлчилгээ, технологи шуудангийн салбарт өргөнөөр нэвтэрч байгаа хэдий ч энэ төрлийн харилцааг Шуудангийн тухай хуулиар зохицуулаагүй байна.

Нөгөө талаас, хүний хөгжлийн явц дахь хотжилт, амьдралын хэв маягийн шинэ төлөвшил, хувьслыг дагаж дэлхийн улс орнуудын шуудангийн үйлчилгээний ангилал, төрөл нэмэгдэж, шинэчлэгдэж байна. Тухайлбал, цахим шуудангийн үйлчилгээнд виртуаль хүргэлт, ложистик үйлчилгээ зэрэг шуудангийн шинэ нэр төрлийн 120 гаруй үйлчилгээ нэвтрээд байгаа талаар Дэлхийн шуудангийн байгууллага мэдээлсэн байдаг.

3.Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" тогтоол, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 64 дүгээр ""Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай" тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 330 дугаар "2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай" тогтоолыг үндэслэн шуудангийн төрийн мэдлийн үндсэн сүлжээ эзэмшигчийн статусыг хуулиар тодорхой болгох, түүнчлэн үндсэн сүлжээний эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд шуудангийн маркийн үнэ, эзэмшил, эрхлэн гаргах асуудлыг харьяалах статусыг тодорхой болгох, хадгалалт, хамгаалалтыг хариуцах этгээдийг тодорхой болгох хэрэгцээ, шаардлага байна.

4.Монгол Улсын хэмжээнд 50 гаруй аж ахуйн нэгж шуудангийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл эзэмшиж байгаа хэдий ч үүнээс 36 нь үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд энэ нь шуудангийн салбарт хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нэвтрэх, үйл ажиллагаагаа явуулах хууль, эрх зүйн орчин төдийлөн таатай бус байгааг харуулж байна.

5.2017 оны 1 дүгээр улиралд шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн дунд явуулсан шуудангийн тухай хууль тогтоомжийн талаархи судалгаагаар нийт оролцогчдын 64,7 хувь нь "хуучны хэв загвар, нэр томьёотой" гэж үзсэн бөгөөд 41,2 хувь нь"хуулийн заалтууд ойлгомжтой" гэсэн хариулт өгсөн байна.

Монгол Улсын шуудангийн салбарыг уламжлалт үйлчилгээ бүхий өнөөгийн түвшнээс олон улсад өрсөлдөх чадвартай, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, түүний давуу талд тулгуурласан, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, найдвартай, хурдан шуурхай хүргэлтийг хийж чадах, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай шуудан болгон өөрчлөх үндсэн зорилтыг хангахын тулд дээр дурсан үндэслэл, шаардлагыг үндэслэн Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзлээ. Түүнчлэн Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайланд эдгээр асуудлыг шийдвэрлэх шаардлагатайг зөвлөсөн байгаа.

**Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь хэсэгт заасан хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн төрөлд хамаарах бөгөөд Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараахь өөрчлөлтийг тусгана:

1.Шуудангийн салбарын бодлого, зохицуулалтыг хариуцсан байгууллагын бүрэн эрх, чиг үүргийг зааглан тодорхойлж, салбарын удирдлага, зохион байгуулалтын давхардал, илүү шат дамжлагыг арилгана;

2.Монгол Улсын нэгдэн орсон Дэлхийн шуудангийн байгууллагын конвенци, дүрэмд дотоодын хууль тогтоомжийг нийцүүлнэ;

3.Шуудангийн үндсэн сүлжээний тодорхойлолт, эзэмшигчийн статусыг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлох, хувийн хэвшлийн шуудангийн байгууллагуудын оролцоог хангах боломжийг нэмэгдүүлнэ;

4.Шуудангийн нэгдсэн кодын тодорхойлолт, шуудангийн хүргэлтийн давтамж, чиглэл болон хүргэлтийн хугацааг олон улсын жишигт ойртуулах, шуудан илгээмжийн төрөл зүйлийг олон улсын стандартад нийцүүлнэ;

5.Шуудангийн үйлчилгээгээр дамжуулан бусад салбарт шинэ үйлчилгээ, хэрэглээг нэвтрүүлэх, цахим худалдаа, илгээмжийн үйлчилгээг ашиглах боломжийг нэмэгдүүлнэ;

6.Дэлхийн шуудангийн байгууллагаас улс орнуудад хөгжүүлэхийг уриалсан цахим худалдаа, санхүү, даатгал болон хүргэлт зэрэг шинэ үйлчилгээг шуудангийн салбарт нэвтрэх боломжийг тусгана;

7.Хуулийн зарим зүйл, заалтын агуулга, нэр томьёог боловсронгуй болгоно.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгмийн болон хууль эрх зүйн хүрээнд, төр, хувийн хэвшил болон иргэн, хуулийн этгээд, үйлчилгээ эрхлэгчдийн харилцаанд дараахь зэрэг үр дагавар бий болно гэж үзэж байна. Үүнд:

1.Монгол Улсад аливаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар зүйн байршлаас үл хамааран шуудангийн үйлчилгээнд хамрагдах эрхээ эдлэх нөхцөл сайжирна.

2.Монгол Улсын шуудангийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбогдох харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, тэдгээртэй холбогдуулан гаргасан дүрэм, журмуудын хэрэгжилт сайжирна.

3.Шуудангийн салбарын үйлчилгээний нэр төрөл, оролцогч байгууллагын тоо нэмэгдсэнээр шинэ бизнесийн төрөл, хамрах хүрээ болон санхүүгийн орлого нэмэгдэнэ.

4.Дэлхийн шуудангийн байгууллагын конвенц, бусад дүрэм, журамд шуудангийн эрх зүйн баримт бичгийг нийцүүлснээр олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүргээ Монгол Улс хэрэгжүүлэх боломж сайжирна.

5.Хуулийн нэр томьёо, үг хэллэг, бичвэрийн давхардал болон зөрчил арилна.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хуулийн талаархи санал**

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болох Дэлхийн шуудангийн байгууллагын холбооны конвенци, дүрэм болон бусад хууль тогтоомжид нийцсэн болно.

---oOo---

## ШУУДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" баримт бичигт тулгуурлан Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого"-ын 3.2.1-д Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрх зүйн тогтолцоо, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох замаар салбарын хөгжлийн таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд "Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрх зүйн актыг боловсронгуй болгож, Монгол Улсын хууль болон олон улсын гэрээнд нийцүүлэн шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ." гэж заасныг үндэслэн Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулллаа.

Уг хуулийн төсөл 7 зүйлтэй.

Хуулийн төсөлд Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайлан болон Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн Давхардал, хийдэл, зөрчлийн судалгааны тайлан, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд заасны дагуу дараахь нэмэлт, өөрчлөлтийг тусгасан. Үүнд:

-"Захидал", "боодол", "шуудангийн хайрцаг", "шуудангийн нэгдсэн код", "шуудангийн үндсэн сүлжээ", "шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч", "шуудангийн үйлчилгээ" зэрэг нэр томьёог Монгол Улсын олон улсын гэрээ, олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлов.

-Шуудангийн салбарын бодлого, зохицуулалтыг хариуцсан байгууллагын бүрэн эрх, чиг үүргийг зааглан тодорхойлж, салбарын удирдлага, зохион байгуулалтын давхардал, илүү шат дамжлагыг арилгахтай холбогдсон зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Тухайлбал, Шуудангийн талаархи Засгийн газрын бүрэн эрхэд шуудангийн нэгдсэн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журам болон шуудангийн үндсэн сүлжээ ашилах эрх олгох, хяналт тавих журам батлахаар, шуудангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхэд шуудангийн маркийн улсын фондыг баяжуулах, хадгалах, хамгаалах, хяналт тавих журам батлах, олон улсын шуудангийн байгууллагад Монгол Улсыг төлөөлөх, холбогдох санал, дүгнэлт боловсруулах, олон улсын байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулахаар нэмж тусгасан.

Түүнчлэн Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрхэд шуудангийн харилцан холболтын журмыг баталж, хэрэгжилтийг хангуулах, шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэхээр нэмж тусгасан.

-Шуудангийн салбарт шинээр нэвтэрч байгаа интернэтэд болон цахим сүлжээнд суурилсан шинэ үйлчилгээ, технологитой холбогдсон харилцааг зохицуулах зохицуулалтыг тусгав. Тухайлбал, Шуудангийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээд нь шуудангийн сүлжээгээр дамжуулан цахим худалдааг

Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын дагуу захиалгат илгээмжийн худалдаа эрхэлж болохоор заасан.

-Шуудангийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээд буюу шуудангаар үйлчлэгч нь шуудангийн үйлчилгээний чанар, үндэсний стандартыг хангаж байгаа тухай мэдээллийг үйлчлүүлэгчид гаргаж өгөх буюу мэдээлэх, сүлжээнд нь бусад үйлчлэгч холбогдоход өөрийн сүлжээг нээлттэй байлгах үүрэг хүлээх бол шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч нь шуудангийн үндсэн сүлжээ, түүний хэрэгслийг зохих журмын дагуу бусад үйлчлэгчид ижил нөхцөлөөр түрээслүүлэх зохицуулалтыг тусгасан.

Хуулийн төсөлд хуулийн зүйл, заалтын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, нэр томьёог жигдлэх, хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын хэл зүй, найруулгыг ойлгомжтой, тодорхой болгох үүднээс найруулгын шинжтэй зарим өөрчлөлтийг хийсэн болно.

Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судлах, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулах шатанд шуудангийн үйлчилгээ эрхлэгч 20 байгууллага, 6000 иргэдээс судалгаа авсан бөгөөд холбогдох хууль тогтоомж, дүрэм журам болон 6 улсын Шуудангийн тухай хууль тогтоомжийг судалсан.

Олон нийтээс санал авах зорилгоор Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаархи хэлэлцүүлгийг Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй хамтад нь 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулсан бөгөөд хуулийн төсөлтэй холбоотойгоор давхардсан тоогоор 44 санал ирүүлснийг судлан үзэж, хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн холбогдох саналыг хуулийн төсөлд тусгасан болно.

Мөн санал авах зорилгоор хуулийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны цахим хуудсуудад байршуулсан бөгөөд тусгайлсан санал ирээгүй болно.

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцсэн бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулллаа.

**-ооОоо-**

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## ШУУДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Шуудангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 3.1.12- 3.1.14 дэх заалт:**

"3.1.12."шуудангийн үндсэн сүлжээ" гэж төрийн өмчийн оролцоотой, бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэгч шуудангийн сүлжээг;

3.1.13."шуудангийн үйлчилгээ" гэж үйлчлүүлэгчээс шуудангийн илгээмж хүлээн авч шуудангийн сүлжээгээр дамжуулан хаягласан эзэнд нь хүргэх нэгдмэл үйл ажиллагааг;

3.1.14."үйлчлүүлэгч" гэж шуудангийн үйлчилгээг авч байгаа иргэн, хуулийн этгээдийг."

**2/6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалт:**

"6.1.5.шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журам батлах;"

**3/7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт:**

"7.1.8.олон улсын шуудангийн байгууллагад Монгол Улсыг төлөөлөх, холбогдох санал, дүгнэлт боловсруулах, олон улсын байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;"

**4/9 дүгээр зүйлийн 9.1.4- 9.1.6 дахь заалт:**

"9.1.4.хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, зохицуулалтын баримт бичиг болон холбогдох журам батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;

9.1.5.шуудангийн харилцан холболтын журмыг баталж, хэрэгжилтийг хангуулах;

9.1.6.шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх;"

**5/16 дугаар зүйлийн 16.3.5, 16.3.6 дахь заалт:**

"16.3.5.өөрийн сүлжээг бусад үйлчлэгч холбогдоход нээлттэй байлгах;

16.3.6.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22.2-т заасны дагуу бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд хөрөнгө төвлөрүүлэх;"

**6/17$^{1}$ дүгээр зүйлийн 17$^{1}$.2.3 дахь заалт:**

"17$^{1}$.2.3.Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийг хариуцах."

**7/19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг:**

"19.2.Шуудангийн илгээмжийг хүргэх хугацаагаар нь ердийн, буухиа гэж зэрэглэнэ."

**8/25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг:**

"25.3.Шуудангийн маркийн хадгалалт, хамгаалалт, хөгжилд зарцуулах санг үүсгэх ба сангийн удирдлага, зохион байгуулалтыг шуудангийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна."

**2 дугаар зүйл.**Шуудангийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн "хууль тогтоомж нь" гэсний дараа "Иргэний хууль," гэж, 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтын "ажиллагаа" гэсний дараа "аюулгүй," гэж, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын "цаг үеийн" гэсний өмнө "хүн амд шуудан, хэвлэл хүргэх ажлыг зохион байгуулах," гэж, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн "тээврийн буудал," гэсний дараа "орон нутгийн замын пост, гүүр," гэж, 17$^{1}$ дүгээр зүйлийн 17$^{1}$.1.2 дахь заалтын "журмын дагуу" гэсний дараа "ижил нөхцөлөөр бусад үйлчлэгчид" гэж, 19 дүгээр зүйлийн гарчгийн "төрөл" гэсний дараа ", зэрэглэл" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Шуудангийн тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5 дахь заалт:**

"3.1.4."захидал" гэж тодорхой этгээдэд хаягласан, дугтуйлсан болон дугтуйлаагүй гар бичмэл, хэвлэмэл баримт бичиг агуулсан шуудангийн илгээмжийг;

3.1.5."боодол" гэж тодорхой этгээдэд хаягласан, эд зүйлс агуулсан битүүмжлэгдсэн шуудангийн илгээмжийг;"

**2/3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт:**

"3.1.8."шуудангийн хайрцаг" гэж шуудангийн илгээмжийг цуглуулах, хүргэхэд ашиглах зориулалтаар тодорхой цэгт байрлуулсан хэрэгслийг;"

**3/3 дугаар зүйлийн 3.1.10, 3.1.11 дэх заалт:**

“3.1.10.“шуудангийн нэгдсэн код” гэж үйлчлүүлэгчийн байршлыг тодорхойлсон тоо болон үсэг, тооны хосолсон илэрхийллийг;

3.1.11.“шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч” гэж шуудангийн бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэгч байгууллагыг;”

**4/7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалт:**

“7.1.5.шуудангийн үнэт цаас, маркийг үйлдвэрлэх бодлого боловсруулах, шуудангийн үнэт цаас, маркийн улсын фондыг баяжуулах, хадгалах, хамгаалах, хяналт тавих журам батлах;”

**5/10 дугаар зүйлийн 10.2.2 дахь заалт:**

“10.2.2.үйлчлэгчийн боловсруулсан аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг болон хот, тосгоны доторх шуудангийн илгээмж хүргэх хуваарь, чиглэлийг тухайн шатны Засаг дарга.”

**6/14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг:**

“14.1.Үйлчлэгч нь Зохицуулах хорооноос баталсан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын дагуу захиалгат илгээмжийн худалдаа эрхэлж болно.”

**7/21 дүгээр зүйл:**

**“21 дүгээр зүйл.Улс хоорондын шуудангийн илгээмж**

21.1.Улс хоорондын агаарын болон газрын шуудангийн илгээмжтэй холбоотой үйл ажиллагаанд Монгол Улсын олон улсын гэрээ болон үйлчлэгч хоорондын гэрээ, холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

21.2.Улс хоорондын шуудангийн илгээмжид улс хоорондын шуудангийн сүлжээгээр дамжин хилийн чанадаас Монгол Улсын нутаг дэвсгэрт хүргэгдэж байгаа, Монгол Улсаас хилийн чанадад илгээж байгаа, эсхүл дамжин өнгөрч байгаа шуудангийн илгээмж хамаарна.”

**8/24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт:**

“24.1.1.Галт зэвсгийн тухай хуулийн 3.1.1-3.1.4, 3.1.6-д заасан галт зэвсэг, сум, байлдааны зориулалттай галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан химийн хорт болон аюултай бодис, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэл;”

**9/24 дүгээр зүйлийн 24.1.3 дахь заалт:**

“24.1.3.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 3.1.1, 3.1.4-т заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эд;”

**10/25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг:**

“25.2. Шуудангийн марк нь Монгол Улсын тусгаар тогтнолыг илэрхийлсэн, шуудангийн илгээмжийн төлбөр төлөгдсөнийг баталгаажуулсан шуудангийн үнэт цаас болно.”

**4 дүгээр зүйл.**Шуудангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн гарчгийг “Шуудангийн төрөл” гэж, мөн зүйлийн 4.3 дахь хэсгийн “тогтооно” гэснийг “баталж мөрдүүлнэ” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын “бүсчлэлийн” гэснийг “шуудангийн нэгдсэн” гэж, 7 дугаар зүйлийн гарчгийн “Засгийн газрын гишүүний” гэснийг “төрийн захиргааны байгууллагын” гэж, мөн зүйлийн 7.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.2.1 дэх заалтын “Засгийн газрын гишүүн” гэснийг “төрийн захиргааны байгууллага” гэж, 7 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 7.1 дэх хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “бодлого” гэснийг “журам” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.1 дэх заалтын “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 11 дүгээр зүйлийн гарчгийг “Шуудангийн сүлжээний ашиглалт” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “20 дугаар зүйлд заасан” гэснийг “9.1.6-д заасны дагуу тогтоосон” гэж, 13 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 13.2 дахь хэсгийн “Электрон” гэснийг “Цахим” гэж, 13.1, 13.2 дахь хэсгийн “электрон” гэснийг “цахим” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “орон нутгийн” гэснийг “аймаг, нийслэл, сум, дүүрэг,” гэж, 16 дугаар зүйлийн 16.3.3 дахь заалтын “журмын” гэснийг “шуудангийн үйлчилгээний чанар, үндэсний стандартыг хангаж байгаа” гэж, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийн “6.1.3-т” гэснийг “7.1.7-д” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.4 дэх заалтын “Монгол Улсын болон гадаад улсын мөнгөн тэмдэгт” гэснийг “үндэсний валют, гадаад валют” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтын дугаарыг “6.1.6” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтын дугаарыг “7.1.9” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын дугаарыг “9.1.7” гэж, 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалтын дугаарыг “16.3.7” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Шуудангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “шуудангаар” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын “шуудангийн үйлчилгээний давуу эрхийн бүс,” гэснийг, Зургадугаар бүлгийн гарчгийн “, хүргэх хугацаа” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.**Шуудангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 20 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны … дугаар
сарын …-ны өдөр

Улаанбаатар
хот

## МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 дэд заалтын “, шуудан солилцох, хүргэх хуваарь, чиглэлийг батлах” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2018 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 14.3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.4, 3.5 дахь заалт нэмсүгэй:

"3.4.шуудангийн сүлжээ байгуулах, өргөтгөх, татан буулгах тухай Зохицуулах хороо болон хэрэглэгчид урьдчилан мэдэгдээгүй;

3.5.өөрийн сүлжээг бусад үйлчлэгч холбогдоход нээлттэй байлгах үүргээ биелүүлээгүй;"

**2 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 14.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "тээврийн буудал," гэсний дараа "орон нутгийн замын пост, гүүр," гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 14.3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтын дугаарыг "3.6" гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2018 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# ШУУДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН УРЬДЧИЛСАН ТАНДАН СУДАЛГАА

# УДИРТГАЛ

Монгол Улсын “Шуудангийн тухай хууль” нь 2003 оны 05 дугаар сарын 15-нд батлагдсанаас хойш нийт 3 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байдаг.

Хууль батлагдсанаар шуудангийн салбарын хууль эрх зүйн орчин сайжирч, манай улсад зөвхөн төрийн өмчийн төдийгүй хувийн хэвшлийн шуудангийн үйлчилгээ эрхлэгчид үйл ажиллагаа эрхлэх болж, өрсөлдөөн нэвтэрсэн. Ингэснээр шуудангийн сүлжээгээр дамжих илгээмжийн нэр төрөл, тэдгээрийг хүлээн авч дамжуулах хугацаа, үйлчилгээний чанарт тавигдах шаардлагыг өндөрсгөж, мэдээллийн технологийг үйлчилгээндээ нэвтрүүлж, технологи ажиллагааны горимд томоохон ахиц өөрчлөлтүүд гарсныг олон улсын туршлага болон эрдэмтдийн хийсэн судалгаа харуулдаг.

Монгол Улсын шуудангийн талаарх энэхүү судалгааны зорилго нь өмнө гарсан судалгааны ажлууд, тайлан, ДШХ-ны Их хурлуудаас гарсан шийдвэр, тус салбарын мэргэжилтнүүдийн саналыг үндэслэн тулгарч байгаа хүндрэлтэй асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх арга замыг тогтоох, тэдгээрийн эерэг ба сөрөг тал, үр нөлөө болон ижил төрлийн асуудлыг олон улсын болон бусад улсын хууль, эрх зүйн актуудад хэрхэн зохицуулж, шийдвэрлэснийг харьцуулан судалж, хууль тогтоомж боловсруулах хэрэгцээ шаардлагыг тандан судлахад оршино.

## АГУУЛГА


УДИРТГАЛ ........ 1

НЭГ. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ ........ 4

1.1 Шуудангийн салбарын бодлого, зохицуулалт ........ 4

1.2 Шуудангийн салбарын өнөөгийн байдал ........ 4

1.3 Шуудангийн үндсэн сүлжээний хувьчлалын судалгаа ........ 5

1.4 Шуудангийн салбарын судалгаа, шинжилгээ ........ 10

1.5 Асуудлын цар хүрээ мөн чанарыг тодорхойлсон байдал ........ 12

1.6 Эрх хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох ........ 12

1.7. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл ........ 13

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫН ХАРЬЦУУЛАЛТ ........ 15

3.1 Асуудлыг зохицуулах хувилбар ........ 15

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ ........ 17

4.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө ........ 17

4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх ........ 18

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ ........ 20

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ ........ 21

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ ........ 24

НАЙМ. ДҮГНЭЛТ ........ 26

Хавсралт 1._Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө ........ 28

Хавсралт 2._Шуудангийн тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа ........ 35

Хавсралт 3. Шуудангийн тухай хуулиар авсан санал асуулгын дүн ........ 44

Хавсралт 4._Шуудангийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд хийсэн дүгнэлт ........ 47

## ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Шуудангийн үндсэн сүлжээг хувийн хэвшилд шилжүүлсэн тохиолдолд гарах үр дүнгийн харьцуулсан судалгаа....5
Хүснэгт 2. Хувилбарын харьцуулалт....16
Хүснэгт 3. Бусад хууль тогтоомжтой харьцуулсан судалгаа....18
Хүснэгт 4. Хувилбарын харьцуулсан дүгнэлт....20

## ЗУРАГ

Зураг 1. Улс хоорондын шуудангийн илгээлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид 2016 он....4
Зураг 3. Шуудангийн хөгжлийн түвшинг тодорхойлох аргачлалын загвар....7
Зураг 4. Шуудангийн солилцооны өсөлт бууралтын шинжилгээ....8
Зураг 5. Дэлхийн шуудангийн холбооны стратеги зорилтууд....9
Зураг 7. Шуудангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар үйлчилгээ эрхлэгчдээс авсан санал асуулга....11

## НЭГ. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### 1.1 Шуудангийн салбарын бодлого, зохицуулалт

Монгол Улсын шуудангийн салбар нь "Харилцаа холбооны тухай", "Шуудангийн тухай" хуулиуд болон бусад холбогдох хууль, тэдгээрийг дагалдаж, гарсан эрх зүйн баримт бичгүүд, олон улсын гэрээ хэлэлцээрээр зохицуулагдаж байдаг. "Шуудангийн тухай" Монгол Улсын хууль 2003 онд батлагдсанаар шуудангийн салбарт хувийн хэвшлийн байгууллагууд олноор бий болоод зогсохгүй шуудангаар үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, сонголт шинэчлэгдэж, үйлчилгээний болон шуудангийн илгээмжийн нэр төрлийг нэмэгдүүлэх шаардлагатай болж байна. Мөн шуудангийн үндсэн сүлжээний хувьчлалын асуудал, мэдээллийн технологийн хөгжлийг дагасан шинэ бүтээгдэхүүн, технологийн давуу талуудыг шуудангийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх зэрэг өөрчлөлттэй уялдуулан хууль эрхзүйн орчныг сайжруулах уян хатан байдлыг хангасан тогтвортой зохицуулалт шаардлагатай байна.

### 1.2 Шуудангийн салбарын өнөөгийн байдал

Манай улсын шуудангийн салбарт бий болсон нөхцөл байдал, гадаад орнууд болон олон улсын шуудангийн чиг хандлагатай холбогдох харилцааны зохицуулалтаар шуудангаар үйлчлүүлэгч нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллага болон шуудангаар үйлчлэгч 50 гаруй байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байгаа болно. Хэдийгээр улсын хэмжээнд 50 гаруй аж ахуйн нэгж шуудангийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа боловч тэдгээрээс 36 нь үйл ажиллагаа явуулж байгаа нь шуудангийн салбарт хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нэвтрэх хууль эрх зүйн орчин төдийлэн таатай бус байгааг харуулж байна. (Зураг 1 ба 2)

Зураг 1. Улс хоорондын шуудангийн илгээлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид 2016 он



Зураг 2. Улс хоорондын буухиа шуудан, хүргэлт, логистик, дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэгчид 2016 он




## 1.3 Шуудангийн үндсэн сүлжээний хувьчлалын судалгаа

Түүнчлэн Улсын Их Хурлын 2015 оны 07 сарын 03-ны өдрийн 70, Засгийн Газрын 2015 оны 08 сарын 17-ны өдрийн 330 дугаар тогтоолыг үндэслэн шуудангийн төрийн мэдлийн үндсэн сүлжээг эзэмшигч “Монгол шуудан” ХК-ийг Төрийн өмчийн хорооны 2015 оны 09 сарын 28-ны өдрийн 594-р тогтоолоор 100% хувьчлахаар шийдвэрлэсэн. Энэ нөхцөлд төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээг газар нутгийн алслагдмал байдлаас үл хамааран ижил нөхцлөөр хүргэх, Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэг зэрэг олон асуудлыг зохицуулах шаардлагатай болж байна.

Хүснэгт 1. Шуудангийн үндсэн сүлжээг хувийн хэвшилд шилжүүлсэн тохиолдолд гарах үр дүнгийн харьцуулсан судалгаа

| № | Шуудангийн салбарын хүлээх үүрэг | Эрсдэл | Давуу тал | Шийдвэрлэх арга зам |
|---|---|---|---|---|
| 1 | Төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээ | Тогтмол хүргэдэг хүргэлтийн тоо багасч, үнэ өснө. | | Гэрээгээр хатуу үүрэг хүлээлгэх |
| 2 | Аль ч нөхцөлд тухайлбал онцгой байдлын үед саадгүй тогтмол хуваарийн дагуу явах | Хүргэлт хийгдэхгүй байх магадлалтай. | | Шуудангийн хүргэлтийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхой болгох. |
| 3 | Бүх нийтийн үйлчилгээний үүрэг | Үнийн ялгаваргүйгээр хүрэх үйлчилгээний хамрах хүрээ багасна. | БНҮҮС-д төвлөрсөн хөрөнгийг шударга хуваарилах боломжтой болно. | БНҮҮС-гийн хөрөнгийг гүйцэтгэсэн үүрэгтэй нь харьцуулж олгох. |
| 4 | Олон улсад ДШХ-ны конвенцийн дагуу хүлээх үүрэг | Олон улсын шуудангийн нэгдсэн сүлжээнд төрийн өмнөөс үүрэг хүлээн оролцох, санал өгөх асуудал бүрхэг болно. | | ДШХ-ны нэгдсэн сүлжээний өмнө үндсэн сүлжээ эзэмшигчийн хүлээх үүргийг тодорхой болгох. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | Үйлчилгээ энгийн, хүртээмжтэй байх | Хүн ам, нийгмийн бүх давхаргыг ялгаварлахгүйгээр үйлчилгээ хүргэх өртөг нэмэгдэнэ. | Төрөөс алдагдал нөхөхгүй, харин шуудангийн салбарын тоо нэмэгдэж, хөрөнгө оруулалт хийх боломж бүрдэнэ. | |
| 6 | Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан тээврийн сүлжээний байдал | Төрийн мэдлийн тээврийн нэгдсэн найдвартай сүлжээ байхгүй болно. | | Шуудангийн үндсэн сүлжээ төрийн мэдэлд байна гэсэн хуулийн заалтыг баримтлан ажиллана. |
| 7 | Тусгай шуудангийн үйл ажиллагаа | Нууцын зэрэглэл алдагдах, шууданч-төрийн төлөөлөл байх боломжгүй болно. | | |
| 8 | Шуудангийн ажиллагсад | Шуудангийн өндөр настнууд болон ажиллагсдын нийгмийн баталгаанд эрсдэл гарах магадлалтай. | | Шууданчдын нийгмийн асуудлын баталгааг хангуулах тал дээр гэрээнд тусгах, хувьцааны тодорхой хэсгийг хөнгөлөлттэй олгох. |
| 9 | Монгол марк | Маркийн улсын фондын хадгалалт хамгаалалт муудаж, филателийн холбоо зэрэгтэй харьцуулах зохицуулалт алдагдана. | Бусад үйлчилгээ эрхлэгчдэд ижил тэгш нөхцлөөр үйлчлэх боломж гарна. | Маркийн фондын үнэлгээг дахин хийх. |

Дэлхийн шуудангийн холбооны 170 гаруй улс орныг хамруулан хийсэн шуудангийн хөгжлийн түвшинг илтгэх 2IPD буюу нэгдсэн үзүүлэлтийн 2016 оны судалгааны дүнгээ зарласан байна. Шуудангийн хөгжлийн нэгдсэн үзүүлэлт буюу 2IPD нь их хэмжээний өгөгдлийг глобал түвшинд нэгтгэсэн, шуудангийн үйлчилгээний хөгжлийг илтгэх цогц хэмжүүр юм. (Зураг 3)

Судалгааны үндсэн өгөгдөлд 3 тэрбум гаруй бүртгэл хяналтын бичлэг, статистик мэдээлэл ашиглан, анализыг шуудангийн хөгжлийн үндсэн дөрвөн хэмжүүр болох найдвартай байдал, хүртээмж, ач холбогдол, уян хатан байдал гэсэн үзүүлэлтээр ангилан, харьцуулалтын шинжилгээг 0-100 оноогоор дүгнэхэд Монгол Улс 39,41 гэсэн үнэлгээгээр 79-р байрт жагсаж байна. Энэ нь манай улс шуудангийн үйлчилгээнд тавигдах шаардлагыг өндөрсгөж (ач холбогдол), хөгжлийн үнэлгээг дээшлүүлэх шаардлагатайг харуулж байна.

Зураг 3. Шуудангийн хөгжлийн түвшинг тодорхойлох аргачлалын загвар




Шуудангийн үйлчилгээний хувьд нь 2003 оноос хойш нэр төрөл, ангилал болон тухайн үйлчилгээнд тавигдах шаардлага нь эрс өөрчлөгдсөн байна. Шуудангийн үйлчилгээг бичиг, захидал, боодол, илгээлт, хэвлэл хүлээн авч ялган боловсруулж, тээвэрлэн хаягт эзэнд нь гардуулах үйлчилгээ гэж ойлгож ирсэн бол мэдээллийн технологийн хурдацтай хөгжил нь энэ ойлголтод өөрчлөлт оруулж байна. Тухайлбал:

Шуудангийн илгээмжийн форматаас хамааран:

Жижиг захиа P

Овор ихтэй G

Хэт их овортой E гэж ангилах болсон. Тус бүр нь дээд доод хэмжээний хязгаарыг тогтооcноос гадна үйлчилгээний чанар, үнэ тарифийн хувьд ч өөр өөр байдаг болсон.

DHL, FedEx, UPS зэрэг дэлхийн томоохон буухиа шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн хувьд жижиг боодол (small packets) гэсэн ойлголт бараг хэрэглээнээс гарч, илгээмжийн агуулж байгаа зүйлсээс хамааруулан бичиг, илгээлт гэж хоёр ангилж байна.

Зураг 4. Шуудангийн солилцооны өсөлт бууралтын шинжилгээ




Энэ судалгаанаас харахад шуудангийн илгээлтийн солилцооны өсөлт их байгаа нь цахим худалдааны үйлчилгээний эрэлт хэрэгцээ их байгааг харуулж байгаа бөгөөд энэхүү үйлчилгээг хөгжүүлэхэд одоо мөрдөгдөж байгаа шуудангийн үйлчилгээний болон нэр томъёоны тодорхойлолт төдийлэн шаардлагад нийцэхээргүй байна.

2015 оны 9-р сарын 25-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан “Эх дэлхийгээ шинэчилье” нэртэй 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөрийг дэмжиж, Дэлхийн шуудан холбооны байгууллага 2016 онд “Стамбулын стратеги”-ийг баталсан билээ. Энэхүү хөгжлийн стратеги нь 3 үндсэн зорилттой.

Зураг 5. Дэлхийн шуудангийн холбооны стратеги зорилтууд



## 1.4 Шуудангийн салбарын судалгаа, шинжилгээ

Шуудангийн салбарын эрдэмтэн судлаачдын хийсэн судалгаа болон шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн дунд явуулсан хэлэлцүүлэг, санал асуулгаар нийт оролцогчдын 64.8% одоо мөрдөж байгаа "Шуудангийн тухай хууль" зорилгоо биелүүлдэг гэсэн боловч 64.7 хувь нь хуучны хэв загвараас салаагүй гэсэн үнэлгээг өгсөн (Зураг 5 болон 6). Мөн "Шуудангийн тухай хууль"-ийн заалтууд ойлгомжтой эсэхэд 41.2 хувь нь тийм гэсэн хариулт өгсөн байна. Шуудангийн тухай хуулийг мөрдөн ажиллаж чаддаг эсэх талаар 94.1 хувь нь тийм гэж хариулсан. Энэхүү судалгааны дүнгээс харахад одоо мөрдөж байгаа шуудангийн тухай хууль үүргээ гүйцэтгэж байгаа боловч өнөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшинтэй нийцүүлсэн өөрчлөлт хэрэгтэй байгааг харуулжээ.

Дээрх судалгаанууд болон өгөгдлүүдээс харахад Монгол Улсын шуудангийн салбарт орчин үеийн хэрэглэгчийн эрэлт шаардлагад нийцсэн, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай нийтийг хамарсан өргөн сүлжээг төр хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулах эрх зүйн орчныг таатай болгох шаардлага урган гарч байгаа бөгөөд энэ харилцааг одоогийн хуулиар зохицуулах боломжгүй байна.

Зураг 6. Шуудангийн талаар төрөөс баримтлаж буй бодлогын талаар үйлчилгээ эрхлэгчдээс авсан санал асуулга



Зураг 7. Шуудангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар үйлчилгээ эрхлэгчдээс авсан санал асуулга




Санал асуулгаар нийт оролцогчдын 64.7% нь шуудангийн илгээмжийн ангилал болон стандарт хуучин хэвшмэл загварт баригддаг гэж хариулсан байна.

Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг хөдөө орон нутаг болон УБ хотын 6000 хэрэглэгчээс авч дүнг нэгтгэхэд судалгаанд хамрагдагсдын "Та цахим худалдааны үйлчилгээ шаардлагатай гэж үзэж байна уу?" гэсэн асуултанд хотын иргэдийн 63.2, хөдөөгийн иргэдийн 48.4 хувь тийм гэж хариулсан нь цахим худалдааны үйлчилгээ хот, хөдөөгүй хэрэгтэй байгааг харуулж байна. (Хавсралт 2 ба 3)

**1.5 Асуудлын цар хүрээ мөн чанарыг тодорхойлсон байдал**

Энэхүү хуулийг дагаж мөрдөн хэрэгжүүлж эхэлснээс хойших 15 жилийн хугацаанд шуудангийн үйлчилгээ эрхлэгч хувийн хэвшлийн байгууллагууд олноор бий болж, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, сонголт өсөн нэмэгдэж, мэдээллийн технологид суурилсан шинэ дэвшилтэт үйлчилгээгээр өргөжих болсноор шинэ нэр томъёо, харилцаа, үйлчилгээ нь одоогийн хуулиар зохицуулагдахгүй байгаа асуудлууд тулгарч байна. Үүнд:

1. Шуудангийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр томъёо, үйлчилгээний төрлүүдийн ангилал, сүжээний ашиглалтыг илүү уян хатан болгох;
2. Шуудангийн салбарын бодлого, зохицуулалтыг хариуцсан байгууллагын бүрэн эрх, чиг үүргийг зааглан тодорхойлж, салбарын удирдлага, зохион байгуулалтын давхардал, шат дамжлагыг арилгах;
3. Шуудангийн үндсэн сүлжээний тодорхойлолт, эзэмшигчийн статусыг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлох, ингэснээр хувийн хэвшлийн шуудангийн байгууллагуудын оролцоог хангах боломжийг нэмэгдүүлж, өрсөлдөөний орчин нөхцлийг сайжруулах;
4. Монгол маркийн улсын фондын эзэмшил, хадгалалт, хамгаалалт, хяналт тавих хариуцлагыг тодорхой болгох;
5. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн талаарх Засгийн газрын тусгай сангийн тухай хуультай давхардсан заалтыг тодорхой болгон маргаантай асуудлыг шийдвэрлэх;
6. Захиргааны Ерөнхий хууль болон Зөрчлийн тухай хуультай нийцүүлэн Шуудангийн тухай хуулийн хариуцлагын хэсэгт холбогдох өөрчлөлтийг оруулах асуудлуудыг тус тус зохицуулна.

Энэ хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын болон Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын А/17тоот/ А/52 тоот хамтарсан тушаалаар байгуулагдсан Шуудангийн тухай хуулийн хэрэгжилт, уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эсэх талаар тандан судалгаа хийх ажлын хэсгийн гишүүдийн гаргасан санал, холбогдох тооцоо судалгаа дүгнэлт, зөвлөмж зэргийг судалж үзсэн болно.

**1.6 Эрх хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох**

Шуудангийн тухай хуулиар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага шуудангийн илгээмжийг битүүмжлэн дамжуулах, солилцох замаар Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон иргэний захидал харилцааны нууцыг хамгаалах нөхцлийг баталгаажуулсан шуудангийн сүлжээ, түүний ашиглалт, үйлчилгээтэй холбогдсон

харилцааг зохицуулдаг. Энэхүү харилцаа нь нийгмийн бүхий л бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагууд ямар нэг ялгаваргүйгээр тэгш эрхтэйгээр оролцдог. Иймд шуудангийн салбарт уламжлалт үйлчилгээ бүхий өнөөгийн түвшнээс мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, түүний давуу талд тулгуурласан, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, найдвартай, хурдан шуурхай хүргэлтийг хийж чадах, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай шуудан болгон өөрчлөх үндсэн зорилтыг хангахад Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатайг хэрэглэгчдийн дунд явуулсан судалгаагаар тодорхойлов. (Хавсралт 4)

Нөгөө талаас Улсын хэмжээнд 50 гаруй аж ахуйн нэгж шуудангийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл эзэмшиж байгаа бөгөөд эдгээрээс 36 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь тус салбарт хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нэвтрэх, үйл ажиллагаагаа явуулах хууль, эрх зүйн орчны дэмжсэн нөхцлийг бүрдүүлж чадахгүй байгааг харуулдаг. (Хавсралт 3)

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар тус хуулийн хүрээнд эрх ашиг нь хөндөгдөж байгаа иргэн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, албан байгууллагын хувьд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэхгүй бөгөөд харин эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор шуудангийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэж, шуудангийн байгууллагад хандан үйлчлүүлж буй иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нөхцөл сайжирна.

**1.7. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл**

Холбогдох судалгаануудыг харьцуулан дүгнэхэд Шуудангийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад маргаантай, шийдвэл зохих дараах асуудлууд байсаар байна. Үүнд:

1. Шуудангийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн зүйл заалтуудад тусгагдсан Хяналт, хариуцлагын тухай асуудлыг УИХ-аар одоо батлагдах “Зөрчлийн тухай хууль”-тай харьцуулан, уялдуулах.
   Шуудангийн сүлжээний ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, техник технологийн горимын хэрэгжилтэд хууль тогтоомжид заасны дагуу улсын байцаагч хяналт тавина гэсэн нь тусгай зөвшөөрлийн гэрээний биелэлтийг хянахад заавал улсын байцаагч байлцах болсноор ажиллагааг дамжлага ихтэй болгож байна.

2. Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.3 дахь заалтуудтай нийцүүлэн шуудангийн үйлчилгээ эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг тодорхой болгох.
   Тухайлбал: Харилцаа холбооны зохицуулах хорооны эрх зүйн байдлын тодорхойлсон Харилцаа холбооны тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль тогтоомжоор Зохицуулах хороонд мэдээлэл, харилцаа холбооны талаарх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж буй эсэхэд хяналт тавих эрхтэй

байхаар заасан боловч "Үйлчилгээний чанарыг хянах журам" батлах эрхийг тусгайлан олгоогүй тул дээрх журам нь хэм хэмжээний акт болохын хувьд Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.3 дахь хэсэгт заасан "хуулиар тусгайлан эрх олгогдсон байх" шаардлагыг хангахгүй байгаагаас үйлчилгээний чанарыг хянах боломжгүй болсон.

Шуудангийн салбарт олгогдож байгаа тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох асуудал орхигдсон нь Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт "Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно." гэснийг болон мөн хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалтад "Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд нийцсэн байх;" гэж, 60.1.3 дахь заалтад "тэмдэглэх хэсэгт үндэслэл болгож байгаа хуулийн заалтыг заасан байх;" гэж, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтад "харилцаа холбооны талаар баримталж буй бодлогын хүрээнд хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, түүнийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавих, гэрээ байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Аж ахуйн үйл ажиллагааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад "тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих;" гэж тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын чиг үүргийг заасан бөгөөд тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг батлах бүрэн эрхийг олгоогүй байна.

3. Шуудангийн илгээмжийн жин, хэмжээг хуулийн заалт болгон тусгасан нь шинэ нэр төрлийн үйлчилгээг нэвтрүүлэхэд хүндрэлтэй байдаг тул хуулийн заалтаар бус стандартаар зохицуулдаг болох;
4. Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшич нь урьд нь 100% төрийн өмчит байсан бол өмчийн хэлбэрт өөрчлөлт орсонтой холбогдуулан төрийн мэдлийн шуудангийн сүлжээний талаар баримтлах зохицуулалтыг уян хатан болгож зохицуулах;
5. Шуудангийн тухай хуульд Засгийн газрын гишүүний бүрэн эрх гэсэн заалтыг Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хууль болон Захиргааны Ерөнхий хуультай нийцүүлэн өөрчлөх;
6. Шуудангийн маркийн улсын фондыг хариуцах болон үнэт цаасны талаарх асуудлыг ойлгомжтой болгох;
7. Шуудангийн хүргэлтийн хугацааг хуульчлан заасснаар үйлчилгээний чанарын үзүүлэлтүүдийг хэрэглэгчдийн эрэлтэд нийцүүлэн тухай бүр шинэчлэн тогтооход хүндрэл учирдаг.
8. Шуудангийн кодыг Шуудангийн тухай хууль болон Засгийн газрын журамд өөр өөрөөр тусгасанг (ZIP code, бүсчлэлийн код, шуудангийн код, шуудангийн нэгдсэн код гэх мэт) нэгдмэл нэг нэршилд оруулж, олон нийтэд ойлгомжгүй байгааг цэгцлэх.

## ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫН ХАРЬЦУУЛАЛТ

Энэхүү судалгааны нэг дэх хэсэгт тодорхойлсон асуудал, түүнийг үүсгэж буй шалтгаан нөхцлийг арилгах арга замын хувилбарыг Шуудангийн хөгжлийн нэгдсэн үзүүлэлтийг (үнэлгээг 60-аас дээш болгох) нэмэгдүүлэх зорилгод хүрэх байдал, зардал үр өгөөж, үр нөлөөгөөр нь дараах байдлаар харьцуулан үзэв.

### 3.1 Асуудлыг зохицуулах хувилбар

3.1.1. "Тэг" хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах:
Энэ хувилбар нь шуудангийн хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогыг Засгийн газар тодорхойлдог, Мэдээлэл, харилцаа холбооны чиг үүргийн төрийн захиргааны төв байгууллага байхгүйгээс, эдгээр бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн тулд ЗГХЭГ-т хандах зэргээр илүү шат дамжлага үүсч, хугацаа алддаг. Зохицуулалтгүй орхисон тохиолдолд төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт, иргэдийн захидал харилцаагаа нууцлах тухай үндсэн хуулиар олгогдсон эрхээ баталгаажуулахад хэрэглэгчдэд эрсдэл учрах магадлалтай.

3.1.2. Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх:
Хэрэглэгчийн эрэлтэд нийцсэн стандарт шаардлагыг хангасан бүтээгдэхүүн нийлүүлэх хуулийн зохицуулалттай холбоотой тул шуудангийн салбарын үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээний талаар мэргэжилтэн, судлаач, хэвлэл мэдээллийн байгууллагуудаас зохион байгуулах сурталчилгааны энэхүү хувилбар нь шуудангийн хөгжлийн нэгдсэн үзүүлэлтийн үнэлгээг нэмэгдүүлэхэд үр дүн гарахаар нөлөөлөхгүй гэж үзэж байна.

3.1.3. Зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулалт хийх:
Асуудал нь татвар, хураамжтай холбоогүй, зөвшөөрөл лицензтэй холбоотой хуулийн зохицуулалтаас үүдэлтэй тул энэхүү хувилбарыг хэрэгжүүлэх боломжгүй, үр дүн гарахгүй юм.

3.1.4. Төрөөс санхүүгийн интервенц хийх:
Асуудал нь шуудангийн салбарын хөгжлийн түвшингийн нэгдсэн үзүүлэлтийг нэмэгдүүлэхэд үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг чиглүүлж, үйл ажиллагаагаа эрхлэх эрх зүйн таатай орчин бүрдүүлэхэд оршиж байгаа буюу аливаа мөнгө, санхүүгийн дутагдал, хүндрэлтэй холбоогүй, хуулийн зохицуулалттай холбоотой асуудал тул энэ хувилбарыг хэрэгжүүлэх боломжгүй болно.

3.1.5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх:
Иргэн аж ахуйн нэгжийн захидал харилцаагаа нууцлах тухай Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөгөө эдлэх нөхцлийг баталгаажуулахад шуудангийн үйлчилгээ эрхлэгч төрийн зохицуулалттайгаар алслагдсан хөдөө орон нутгийн, сум суурин газарт алдагдал хүлээн үүрэг гүйцэтгэж байна. Энэ үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх нь эрсдэлтэй тул энэхүү хувилбар нь асуудлыг шийдвэрлэж зорилгод хүргэх боломжгүй.

3.1.6. Захиргааны шийдвэр гаргах:

Шуудангаар санхүүгийн үйлчилгээ эрхлэхэд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх, Дипломат шуудангийн бүрэлдэхүүнд багтаах, шивээсэн үсэгтэй (секограмм) номыг шуудангаар дамжуулах, УБ хотод шуудан тээврийн автомашиныг дугаарын хязгаарлалтад хамааруулахгүй байх асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран захиргааны шийдвэр гаргах замаар зохицуулах шаардлагатай.

3.1.7. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах:
Иргэн аж ахуйн нэгжийн захидал харилцаагаа нууцлах тухай Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрх, чөлөөгөө эдлэх нөхцлийг баталгаажуулах нь шуудангийн хөгжлийн түвшингээр тодорхойлогдох бөгөөд түүнийг бууруулж байгаа гол үзүүлэлт нь хуулийн зохицуулалт, түүний хэрэгжилттэй шууд холбоотой болох нь судалгаагаар тогтоогдсон.

Тухайлбал, шуудангийн илгээмжийн нэр төрөл, хүргэлтийн хяналтын хугацааг хуулинд зааснаар шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, үйлчилгээний чанарын шаардлагад өөрчлөлт оруулахад хүндрэлтэй байдаг тул үүнтэй холбоотой заалтуудыг өөрчилж үндэсний стандартаар тодорхойлох, өөрчлөлт оруулах г.м.

Хуулийн өөрчлөлтийг шуудангийн салбарын хөгжилд сөргөөр нөлөөлж байгаа шалтгааныг арилгахад чиглүүлэн, судлаачийн судалгааны ажил, олон улсын байгууллагын зөвлөмж зэрэгт тулгуурлан дараах байдлаар төсөөлөв.

Дээрх хуулийн зохицуулалтыг хийснээр судалгаанд ашигласан "шуудангийн хөгжлийн нэгдсэн үзүүлэлт" 31.49-өөс 60 болж зорилго хангагдана гэж тооцож байна.

Иймд асуудлыг хуульд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх энэхүү хувилбар нь сонгон харьцуулсан хувилбаруудаас <u>хамгийн үр дүнтэй хувилбар</u> гэж үзлээ.

Асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг харьцуулж тоймлон үзвэл:

Хүснэгт 2. Хувилбарын харьцуулалт

| Хувилбар | Зорилгод хүрэх байдал | Зардал, үр өгөөжийн харьцаа | Үр дүн |
|---|---|---|---|
| Тэг хувилбар | Шуудангийн салбарын талаарх төрөөс баримтлах бодлого болон хуулийн зохицуулалтгүй асуудал хэвээр үргэлжилнэ. | Зардал гарахгүй боловч асуудлаас үүдэн бий болж байгаа сөрөг үр дагавар үргэлжилнэ. Чирэгдэл хэвээр, тойруугаар хохирол зардал гарна. | Сөрөг үр дагавартай |
| Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх | Зорилгод богино хугацаанд, шууд хүрэх боломжгүй. Хууль тогтоогч, бодлого боловсруулагч, шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд асуудлын мөн чанарын талаар ойлголт төлөвшиж, бодит үйл ажиллагаа явуулахад ихээхэн цаг хугацаа шаардана. | Хэвлэл мэдээлэл, олон нийтэд таниулах зорилготой холбоотой сургалт, нэвтрүүлэг, ухуулга хийх нэмэлт зардал гарах бөгөөд энэ талаар хийгдэж буй арга хэмжээ эерэг үр дагаврыг шууд богино хугацаанд үүсгэхгүй. | Үр дүнгүй |

| | | | |
|---|---|---|---|
| Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх | Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй. | Зардал гарч, үр өгөөж тооцох боломжгүй. | Үр дүнгүй |
| Төрөөс санхүүгийн интервенци хийх | Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй. | Зардал гарч, үр өгөөж өгөхгүй. | Үр дүнгүй |
| Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх | Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй. | Зардал, үр өгөөж тооцох боломжгүй. | Үр дүнгүй |
| Захиргааны шийдвэр гаргах | Асуудал нь холбогдох бусад хууль, журмын зохицуулалттай бөгөөд захиргааны шийдвэр гаргах замаар шийдвэрлэгдэх боломжтой | Зардал гарахгүй | Үр дүнтэй |
| Хууль тогтоомжийн төсөл боловсруулах | Асуудал тодорхой хариуцах эзэнтэй болж, зохицуулалт, хууль эрхзүйн орчин сайжирна. | Ихээхэн зардал гаргахгүйгээр үр өгөөжтэй болгоно. | **Үр дүнтэй.** |

Хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон эерэг ба сөрөг талыг зардал, үр өгөөжөөр харьцуулсны үр дүнд "хуулийн төсөл боловсруулах" нь асуудлыг шийдвэрлэх хувилбар буюу хууль гаргах хэрэгцээ, шаардлагатай гэж үзсэн тул тандан судлах ажиллагааг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

## ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

### 4.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

4.1.1 Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Шуудангийн олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг хүний эрх, эрх чөлөөг хангаН оршин суугаа газар, нас хүйс, ялгаварлахгүйгээр хүргэх нөхцлийг бүрдүүлнэ.

4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Шуудангийн салбар нь өөрөө үйлчилгээний үйлдвэрлэл явуулснаараа эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулна.

4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Ажлын байр бий болгох, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээг бодитоор хүргэхэд эерэг нөлөөтэй.

4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хууль батлагдсанаар байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Хавсралт 1-д хүснэгтээр дэлгэрэнгүй тайлбарыг хийлээ.

### 4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Шуудангийн салбартай холбоотой хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт 11 хууль тогтоомж болон дүрэм журмын судалгааг хийлээ. Үүнд:

Хүснэгт 3. Бусад хууль тогтоомжтой харьцуулсан судалгаа

| | Нэр | Дүрэм журам | Огноо | Дугаар | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Шуудангийн тухай | | | | |
| 2 | Засгийн газрын тогтоол | Төрийн тусгай шуудан харилцааны журам | 1995 | 166 | Монгол Улсын Ерөнхийлөгч,Улсын Их Хурал, Засгийн газар, тэдгээрийн ажлын албадын бүх төрлийн мэдээ, баримт бичиг,биет зүйлийг төрийн нууцад хамаарах эсэхийг үл харгалзан хүлээн авч шуудан холбооны буюу тухайн байгууллагад зохих хаягаар тогтоосон журмын дагуу хүргэж үйлчлэх, төрийн захиргааны төв байгууллагуудын төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, биет зүйлийг ердийн болон нууцлалтай шуудангаар дамжуулж хүргэх ажлыг Төрийн холбооны газрын тусгай шуудан харилцааны алба /цаашид "Шуудан харилцааны алба" гэнэ/ хариуцна. |
| 3 | Засгийн газрын тогтоол | Шуудангийн шинэ нэр төрлийн үйлчилгээ нэвтрүүлэх тухай | 1997 | 99 | Улсын төсвийн орлого, зарлага, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэл, татварын төлбөр тооцоо, мөнгөн хадгаламж болон гүйвуулгыг шуудангийн уламжлалт үйлчилгээтэй нэгтгэн, холбогдох төлбөр тооцооны дансыг "Монгол шуудан" компани, түүний харъяа алба, салбаруудад байршуулан гүйцэтгүүлэх ажлын бэлтгэлийг хангаж 1997 оны 6 дугаар сарын 1-нээс Ховд аймагт эхлэн туршиж үр дүнг энэ оны 9 дүгээр сард багтаан Засгийн газарт оруулсугай;<br>б/шинээр нэвтрүүлж буй үйлчилгээг иргэдэд сурталчилах, тэнд ажиллагчдыг сургалтад хамруулах, маягт, материал хэвлүүлэх, зарим ажлын байрыг зориулалтын техник хэрэгслээр тоноглох зэрэг арга хэмжээ авсугай |
| 4 | Гадаад хэргийн сайд | Монгол улсын дипломат шууд ангийн албаны журам | 1999 | 45 | Энэхүү журмыг Дипломат харилцааны тухай 1961 оны Венийн конвенцийн 27 дугаар зүйлийн заалтыг үндэслэн гаргав Дипломат шууданг осол эндэгдэлгүй, найдвартай, шуурхай хүргэх, нууцлах шаардлагыг хангахад Дипломат шуудангийн албаны гол зорилго оршино.<br>3. Монгол Улсын Гадаад харилцааны яам /ГХЯ/, хилийн чанадад суугаа Дипломат болон консулын төлөөлөгчийн газруудын /ДКТГ/ хооронд харилцан илгээж буй албан бичиг баримт, ачаа тээшээс дипломат шуудан бүрдэнэ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | 4. Дипломат шуудан нь битүүмжлэхээс хэрэглэгчид хүртэл "маш нууц" зэрэглэлтэй байна |
| 5 | Автотээврийн тухай хууль | Нийтийн тээврийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай | 2000 | 80А35 | Автотээврийн тухай хуулийн 15.5.1 дүгээр заалт, Автотээврийн хэрэгслээр нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журмын 2.7-г үндэслэн аж ахуйн нэгжийн авто тээврийн дээд, тусгай дунд боловсролтой хүмүүсийг тээвэрлэгч-менежерээр, жолоочийг тээвэрлэгч-жолоочоор, мөнгө хураагчийг тээвэрлэгч-кондуктороор мэргэшүүлэх зорилгоор эрх бүхий байгууллагын сургалтад хамруулан гэрчилгээ авсан аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг нийтийн зорчигч, такси тээвэрлэлтийн үйлчилгээнд ажиллуулж байхаар 2000 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдсүгэй. |
| 6 | Дэд бүтцийн сайдын тушаал | Аймаг, орон нутагт зорчигч, шуудан тээврийн үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дүрэм | 2002 | 42 | Аймаг, орон нутагт зорчигч шуудан тээврийн үйлчилгээг зохицуулах зөвлөл (цаашид зөвлөл гэнэ)-ийн зорилго нь тухайн орон нутагт зорчигч тээвэр, төрийн шуудан, хэвлэл, иргэдийн захидал харилцааны хүргэлт түгээлтийг зах зээлийн эрэлт нийлүүлэлт, төр засгийн бодлого зохицуулалтад нийцүүлэн хамгийн оновчтой, үр ашигтай, хөнгөн шуурхай, иргэдийн эрх ашигт нийцүүлж, өмчийн харилцаа удирдлагын бүтцэд харшлахгүйгээр зорчигч, шуудан тээврийн ажил үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан нэмэгдүүлсэн, нэгдмэл үйл ажиллагааг зохицуулахад оршино. |
| 7 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль | Наймдугаар бүлэг хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж | 2016 | | 26.1.14.хараагүй хүний брайлийн үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл, 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх |
| 8 | Засгийн газрын тогтоол | Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам | 2009 | 151 | Энэхүү журмын зорилго нь төрийн бодлогын хүрээнд зайлшгүй шаардлагатай мэдээлэл, шуудан, харилцаа холбооны үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх үүргийг хэрэгжүүлүүлэхээр Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан (цаашид "сан" гэх)-д хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | Засгийн газрын тогтоол | Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр | 2010 | 289 | Агаарын хөлөг, багийн гишүүд, зорчигч, ачаа шуудан болон бусад эд зүйлсийг хүндрэл, чирэгдэл, саадгүйгээр улсын хил нэвтрүүлж, хилийн хяналт шалгалтын үйл ажиллагааг давхардалгүй, шуурхай зохион байгуулах, боловсронгуй болгоход Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр (цаашид "Хөтөлбөр" гэх)-ийн зорилго оршино. |
| 10 | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан тушаал | | 2014 | 296 | Энэхүү журмын зорилго нь улс хоорондын шуудангийн илгээмж (цаашид "илгээмж" гэх)-ийг гаалийн хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино |
| 11 | Авто тээврийн тухай хууль | зарим Зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах дээд шүүхийн тогтоол | 2006.2.20 | 05 | 2.Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4.-т "нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэрт зохицуулах, зохион байгуулах" гэдэгт Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1.-д заасны дагуу аймаг хооронд, орон нутаг, хотын доторхи болон хот орчмын нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох эрхтэй аймаг, Нийслэлийн Засаг дарга нь харьяа албаараа дамжуулан нийтийн тээврийн үйлчилгээний замын чиглэл, шугам, цагийн хуваарь зэргийг батлах, тээвэрлэлтийн үйлчилгээний чанарыг сайжруулах талаар арга хэмжээ авах, тээвэрлэлтийн гэрээний үнэ тарифын дээд хязгаарыг тогтоох зэрэг ажиллагааг хамааруулан ойлговол зохино |

## ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Шуудангийн тухай хуулийн хэрэгжилтийн судалгааг хавсралт.2-т нэгтгэн харууллаа. Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах хувилбарыг аргачлалд дурдсан шалгуур үзүүлэлтийн дагуу дараах байдлаар дүгнэв.

Хүснэгт 4. Хувилбарын харьцуулсан дүгнэлт

| Шалгуур үзүүлэлт | Зохицуулалтын хувилбар: Хууль гаргах |
|---|---|
| Зорилгод хүрэх байдал | Эерэг |
| Хүний эрх, эдийн засаг байгаль орчинд үзүүлэх үр нөлөө | Эерэгээр нөлөөлнө. |
| Зардал үр өгөөжийн харьцаа | Хуулийг хэрэгжүүлснээр гарах үр өгөөж, гарах зардлын харьцаа өндөр байна. |
| Гарч болох сөрөг үр дагаврыг илрүүлэх | Байхгүй. |
| Хууль тогтоомжтой нийцтэй эсэх | Нийцтэй. |
| Тухайн зохицуулалтаар хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох | Байхгүй. |

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан шуудангийн салбарын хөгжилд тулгамдсан өнөөгийн асуудлыг цогцоор шийдвэрлэх боломж өндөр байна.

## ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Шуудангийн салбарын хөгжлийн талаар олон улсын санхүүгийн байгууллагын мэргэжилтэн, эдийн засаг, санхүүгийн чиглэлийн судлаач, эрдэмтдийн хийсэн судалгааны баримт материалыг ашиглан бусад улс орнуудын шуудангийн байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль тогтоомжийг судлав. Эрх зүйн тогтолцоо, эдийн засаг, соёл, түүх, газар зүйн байршил зэрэг шалгуурыг харгалзан харьцуулалт хийх улсуудыг сонгож, холбогдох судалгааг хавсралтаар үзүүллээ.

Гадаадын улс орнуудын хууль тогтоомжийн харьцуулсан судалгааг:

1) Хуулийн зорилт;
2) Шийдвэр гаргах эрх бүхий этгээд;
3) Засгийн газартай харьцах харьцаа
4) Үйлчлэгч, үйлчлүүлэгчийн эрх үүрэг гэсэн үзүүлэлт тус бүрээр харьцуулан авч үзлээ.

Хүснэгт 5. Бусад улс орнуудын Шуудангийн тухай хуулийн харьцуулалт

| Монгол Улс | ОХУ | Герман |
|---|---|---|
| Хуулийн зорилт | Энэ хууль нь иргэд аж ахуйн нэгж бүр ОХУ-ын нутаг дэвсгэр дээр мэдээлэл чөлөөтэй хүлээн авах дамжуулах, шуудангаар бичвэр мэдээллийг нууцлан битүүмжилж тараах, солилцох, үндсэн хуулиар олгосон эрхээ эдлэх нөхцлийг бүрдүүлэх, түүний эрх зүйн баталгаат системийг бүрдүүлсэн шуудан холбоог тус улсын нутаг дэвсгэрт зохион байгуулахад чиглэгдэнэ. | Үйлчлүүлэгчдийн ашиг сонирхол, нууцлалыг хамгаалах;<br>Хот хөдөөгийн ялгааг арилган тэнцвэртэй байдлыг хангах<br>Боломжийн үнэ бүхий БНҮ-ний нөхцлийг бүрдүүлэх;<br>Олон нийтийн аюулгүй байдлыг хангаН, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх. |
| Хуулийн нэр томъёоны тодорхойлолт | Шуудан холбоо-шуудангийн илгээмжийг хүлээн авах, хүргэх, тээвэрлэх, боловсруулах, мөнгөн гуйвуулга хийх боломжийг бүрдүүлсэн техник, тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, технологийн нэгдмэл иж бүрдэл болох харилцаа холбооны төрөл<br>Газар нутгийг бүхэлд нь хамарсан, нийтийн хэрэглээний шуудан холбоо, олон улсын шуудан холбоо, шуудан холбооны үйлчилгээ, шуудан холбооны БНҮ, шуудангийн мөнгөн гуйвуулга, шуудан холбооны үйлчилгээ үзүүлэх хугацаа, шуудан холбооны үйлчилгээг ашиглагч, холбооны нууцлалт, шуудан холбооны операторууд, шуудан холбооны байгууллага, шуудан холбооны зохион байгуулалт, шуудангийн сүлжээ, шуудангийн объект, шуудангийн маршрут, шуудан холбооны хэрэгсэл, шуудангийн илгээмж, бичиг захидал, шуудангийн үйлчилгээ авагчийн хаягийн өгөгдөл, шуудангийн индекс, өдөрлөгч, шуудангийн төлбөрийн улсын тэмдэгт, өдөрлөгч машин, | Шуудангийн илгээмжийн төрлүүдийг тээвэрлэх гэсэн утгаар тодорхойлсон.<br>Шуудангийн үйлчилгээ, бичиг захидал, тээвэрлэлт, шуудангийн үйлчилгээний арилжаа, шуудангийн үйлчилгээ, зах зээлд давамгайлагч |

| | | |
|---|---|---|
| | шуудангийн хайрцаг, хаягт эзэн, хэрэглэгчийн шуудангийн хайрцаг, шуудан хэрэглэгчийн шкаф, шуудангийн тулгуур цэгийн шкаф зэрэг нэр томъёог хэрэглэдэг. | |
| Шуудангийн асуудал эрхэлсэн Засгийн Газрын гишүүний бүрэн эрх | -Оросын холбооны төр засгийн байгууллагын бүрэн эрх<br>-Оросын холбооны субьектуудын төр засгийн байгууллагуудын бүрэн эрх<br>- Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын үүрэг<br>-Шуудан холбооны салбарын үйл ажиллагааг удирдах гүйцэтгэх засаглалын холбооны байгууллага | Холбооны засгийн газар Бундестаг болон Бундасратын зөвшөөрөл, шаардлыг дагуу бүх нийтийн үйлчилгээг тодорхойлно. |
| ХХЗХ-ны эрх хэмжээ | Шуудангийн салбарын үйл ажиллагааны болон түүнтэй адилтгах үйл ажиллагааны зохицуулалтыг холбооны салбарын гүйцэтгэх засаглалын холбооны байгууллага хэрэгжүүлнэ. | Энэ хуульд заасан зохицуулалтын бүрэн эрх болон Цахилгаан холбооны хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. |
| Шуудангийн үйлчилгээ | Шуудангийн илгээмжийг хүлээн, авах, боловсруулах,тээвэрлэх, хүргэж гардуулах түүнчлэн мөнгөн гуйвуулга хийх үйлдэл эсвэл үйл ажиллагаа | Шуудангийн үйлчилгээ:<br>1.Бичиг захидал тээвэрлэх<br>2. 20 кг-аас хэтрэхгүй илгээлтийг хаягт эзэнд нь хүргэх<br>3.ном, каталог, сонин сэтгүүл тээвэрлэх |
| Шуудангийн сүлжээ | Шуудангийн объект болон маршрутын иж бүрдэл<br>Шуудан холбооны хэрэгсэл(хөрөнгө) нь Оросын холбооны улсын болон иргэн, хуулийн этгээдийн өмч байж болно. | Онцгойлон тодорхойлоогүй |
| Шуудангийн бүх нийтийн үйлчилгээ | Бичиг захидлыг ОХУ-ын нутаг дэвсгэрийн хязгаар дотор боломжийн үнээр солилцох | ХБНГУ-ын нутаг дэвсгэр дотор хүргэж байгаа хамгийн наад захын чанарын шаардлага хангасан боломжийн үнэ бүхий үйлчилгээ.<br>БНҮ-г Бундестаг, Бундасратын зөвшөөрөл, шаардлагаар Холбооны засгийн газар тодорхойлно. |
| Үйлчлэгчийн эрх, үүрэг | Эрх, хариуцлага | Тусгайлан хуульчлаагүй |

| | | |
|---|---|---|
| Үйлчлүүлэгчийн эрх үүрэг | Эрх, хариуцлага<br>Тэгш эрхтэй<br>Иргэн, байгууллага ОХУ-ын нутаг дэвсгэрт нийтийн шуудангийн үйлчилгээ авах эрхтэй<br>Үйлчилгээний талаар мэдээлэл авах эрхтэй<br>Шуудангийн илгээмжийг хаягаараа хүлээн авах, татгалзах,<br>Зарлах үнийн хэмжээг өөрөө тогтоох үүргийг хариуцлага гэж тодорхойлсон | Тусгайлан хуульчлаагүй |
| Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн эрх үүрэг | Шуудангийн операторын хүлээх хариуцлага | |
| Шуудангийн илгээмжийн төрөл | Задалж заагаагүй | |
| Улс хоорондын шуудангийн илгээмж | Шуудангийн илгээмжийг өөр өөр улсын хууль эрх зүйн зохицуулалт бүхий шуудангийн байгууллагууд хооронд солилцох | |
| Хаяг тодорхойгүй шуудангийн илгээмж | | |
| Шуудангийн марк | Шуудангийн үйлчилгээний төлбөрийн хэрэгсэл | Шуудангийн маркийг үйлдвэрлэх, хэвлүүлэх эрхийг Германы Шуудан Цахилгаан холбооны яам хэрэгжүүлдэг. |

Бусад улс орнуудын шуудангийн хууль, эрх зүйн актад шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн статус болон шуудангийн маркийн зохицуулалтыг хэрхэн тусгасан талаар хийсэн түүвэр судалгааг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

1. **Австралийн шуудангийн корпорацийн акт** нь (1989 он) тус улсын шуудангийн үйл ажиллагааг хянан зохицуулдаг гол эрх зүйн акт юм. Австралийн шуудангийн корпораци нь шуудангийн бүхий л үйл ажиллагааг эрхэлдэг улсын мэдлийн үндсэн сүлжээ эзэмшигч болохыг хуулиндаа тусгаж өгсөн байна. Тус корпораци нь шуудангийн маркийг гаргах, борлуулах бүхий л эрхийг эдлэх ба корпорацийн удирдах зөвлөл болон удирдлагын багийн үүрэг функцийг хуулийн зүйл заалт болгон оруулсан байна. Шуудангийн салбарын хяналт болон үйл ажиллагаанд Австралийн өрсөлдөөн, хэрэглэгчийн комисс үндсэн хяналтыг хийх ба маргааныг Холбооны шүүхээр шийдвэрлэхээр хуулийн зохицуулалттай. Австралийн шуудангийн корпорацийн актад шуудан илгээмжийн тодорхойлолтыг илүү тодорхой зааж өгсөн байхаас гадна шуудангийн салбар нэгж, шуудангийн ажилтан хүний эрх үүрэг, үйлчилгээний нэр төрлийг тодорхой зааж өгсөн байдаг.
2. **Филлиппин улсын шуудангийн үйлчилгээний акт** 1992 онд батлагдсан. Филлиппиний шуудангийн корпорацийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн баримт бичиг юм. Тус корпорацийн хөрөнгийн 55 хувь буюу Ангилал “А” төрийн мэдэлд, 45 хувийг олон нийт эзэмшинэ хэмээн хуулиндаа шууд тусгаж өгсөн байх ба корпорацийн удирдах зөвлөл, удирдлагын менежментийн зохицуулалтын талаар хуулиндаа оруулсан байна. Шуудангийн маркийн үйл ажиллагааг Филиппиний шуудангийн корпораци шууд бие даан зохицуулдаг байх ба үйл ажиллагаанд нь Филиппиний тээвэр, департамент болон Үндэсний цахилгаан холбооны комисс хяналт тавин ажилладаг байна.

3. **Оман улсын шуудангийн үйлчилгээний зохицуулалтын акт** нь 2012 онд батлагдсан. Тус улсын шуудангийн салбарт дээрх эрхзүйн баримт бичгээс гадна 2013 онд батлагдсан шуудангийн үйлчилгээний зохицуулалтын актыг хэрэгжүүлэх журмын акт мөн үйлчилдэг. Шуудангийн бүх нийтийн үүрэг, үндсэн сүлжээг "Оманы шуудан компани" эзэмшинэ хэмээн хуулиндаа зааж өгсөн байна. Шуудан үйлчилгээний нэр төрлийг ангилан тус бүрээр нь лиценз олгодог зохицуулалттай бөгөөд шуудангийн үнэ тариф, маркийн төлөвлөгөөг Оманы тээвэр, холбооны яамны сайд баталдаг. Шуудангийн үйл ажиллагаанд тээвэр, холбооны яам, харилцаа холбооны зохицуулалтын газар хяналт тавин ажиллах ба тодорхой хэмжээгээр мөнгөн торгууль ноогдуулах эрхтэй.
4. **Малтийн шуудан үйлчилгээний хууль** 1975 онд батлагдсан (2014 онд шинэчлэгдсэн). Малтийн шуудан компани үндсэн сүлжээг эзэмшигч бөгөөд шуудангийн бүх нийтийн үйлчилгээ үзүүлэгч нээлттэй хувьцаат компани юм. Шуудангийн салбарын зохицуулалтыг Малтийн харилцаа холбооны газар хариуцан ажилладаг ба шуудангийн тарифын жишиг үнийг баталдаг. Шуудангийн маркийн зөвлөл ажиллах ба зөвлөлийн гаргасан зөвлөмж, төлөвлөгөөний төслийг үндэслэн маркийн төлөвлөгөө ба сэдвийг Засгийн газрын сайд баталдаг.

## ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын болон Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын А/17тоот/ А/52 тоот хамтарсан тушаалаар байгуулагдсан Шуудангийн тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилт, уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эсэх талаар тандан судалгааны ажлын хэсэг 2017 оны 3 дугаар сарын 14-өөс 5 дугаар сарын 16-ныг хүртэл ажилласан болно. Энэ хугацаанд ажлын хэсгийн хурлыг 7 хоног тутам хийж, ажлын төлөвлөгөө, судалгааны явцын тайлан болон ТЕГ, Маркийн газруудын мэдээлэл сонсож хэлэлцэв.

Түүнчлэн Дэлхийн шуудан холбооноос гаргасан гишүүн орнуудад нийтлэг мөрдөгдөх хууль, эрх зүйн актуудын талаарх зөвлөмж, Шуудангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар ажлын хэсгийн гишүүдээс гаргасан санал, уг хуулийг гадаадын зарим улс орны Шуудангийн хууль, эрх зүйн актуудтай харьцуулсан судалгаа, шуудантай холбогдох зүйл заалт бүхий Монгол Улсын хууль, нийтлэг мөрдөгдөх дүрэм, журам, судалгааны анкет бүхий хүснэгтээр шуудангаар үйлчилгээ эрхлэгч 20 байгууллага, Монгол Улсын хэмжээнд шуудангаар үйлчлүүлэгчдийн төлөөлөл болох нийт 6000 иргэдээс авсан судалгааг нэгтгэсэн дэлгэрэнгүй тайланг үндэслэн, 2003 онд батлагдсан Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзээд дараах зөвлөмжүүдийг гаргаж байна. Үүнд:

1. Хуулийн 1.1-д: "Энэ хуулийн зорилт нь шуудангийн сүлжээ, түүний ашиглалт үйлчилгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж заажээ.
   **Зөвлөмж:** *"Энэ хуулийн зорилго нь иргэн, аж ахуйн нэгж захидал харилцаагаа битүүмжлэн дамжуулах, солилцох, нууцлах тухай үндсэн хуулиар олгогдсон эрх, чөлөөгөө эдлэх нөхцлийг баталгаажуулсан*

*шуудангийн* сүлжээ, түүний ашиглалт, үйлчилгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж найруулах;

2. Хуулийн 2.2-т: "Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол тухайн олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө" гэж заажээ.

   **Зөвлөмж:** "Монгол Улсын *нэгдэн орсон* олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол тухайн олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө." гэж найруулах;

3. Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.2-т: "... шуудангийн илгээмжийг хүлээн авах, ялган боловсруулах, тээвэрлэх, гардуулахад зориулалттай техник хэрэгслийн иж бүрдэл" гэж заасан нь шуудангийн сүлжээний бүрэлдэхүүн хэсэг болох салбар, цэг, тэдгээрийн хооронд шуудангийн илгээмжийг тээвэрлэх чиглэлийг бүрхэгдүүлсэн байна.

   **Зөвлөмж:** Шуудангийн тухай хуулийн 3.1.2-т: ***"Шуудангийн сүлжээ гэж шуудангийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын салбар, цэг болон тэдгээрийн хооронд шуудангийн илгээмж тээвэрлэх чиглэлийн нийлбэр цогцыг"*** гэж заасныг хэвээр мөрдөх гэсэн саналыг Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан тусгах;

4. Хуулийн 3.1.5-д: "боодол" гэж 1000 граммаас илүүгүй жинтэй, урт нь 245 мм, өндөр нь 35 мм, өргөн нь 150 мм-ээс илүүгүй хэмжээтэй савласан захидлаас бусад шуудангийн илгээмжийг; 3.1.4-т "захидал" гэж тодорхой этгээдэд хаягласан 500 граммаас илүүгүй жинтэй, дугтуйлсан болон дугтуйлаагүй шуудангийн илгээмжийг; 3.1.6-д "Илгээлт" гэж боодлоос овор хэмжээгээрээ том шуудангийн илгээмжийг гэж тус тус заажээ.

   **Зөвлөмж:** Хуулийн 3.1.4, 3.1.5, 3.1.6 дахь заалтыг Монгол улсын үндэсний стандарт, дүрмээр зохицуулах боломжтой учраас бүхэлд нь мөн 3.1.3 дахь заалтаас "... захидал, боодол, илгээлтийн хэлбэрээр " гэснийг тус тус хасах;

5. Хуулийн 3.1.10-т "шуудангийн код" гэж шуудангаар үйлчлэгчийн салбар, цэгийн байршлыг тоогоор эсхүл үсэг, тоо хосолсон хэлбэрээр илэрхийлсэн дугаарыг гэж заажээ.

   **Зөвлөмж:** "шуудангийн *нэгдсэн* код" гэж шуудангаар *үйлчлүүлэгчийн* байршлыг тоогоор, эсхүл үсэг, тоо хосолсон хэлбэрээр илэрхийлсэн дугаарыг гэж найруулах

6. Хуулийн 3.1.11-д " үндсэн сүлжээ эзэмшигч" гэж Шуудангийн төрийн мэдлийн үндсэн сүлжээг эзэмшигч гэж заажээ.

   **Зөвлөмж:** "үндсэн сүлжээ эзэмшигч" гэж Шуудангийн "***Бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэгч байгууллагыг*** " гэж өөрчлөх;

7. Хуулийн 6.1.4-т "бүсчлэлийн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журмыг батлах" гэж заажээ.

   **Зөвлөмж:** *нэгдсэн* кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журмыг батлах гэж найруулах;

8. Хуулийн 7 дугаар зүйлд "Шуудангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх" гэж заажээ.

   **Зөвлөмж:** "***Шуудангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх:*** гэж өөрчлөх

9. Хуулийн 7.1.5-д Шуудангийн үнэт цаасыг үйлдвэрлэх бодлого боловсруулах, улсын фонд байгуулах, хяналт тавих гэж заажээ.
   **Зөвлөмж:** Шуудангийн үнэт цаасыг үйлдвэрлэх бодлого боловсруулах, улсын фонд байгуулах *журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих* гэж найруулах;
10. **Зөвлөмж:** Хуулийн 9 дүгээр зүйл. Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрхэд "***Шуудангийн илгээмжийн хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх***" гэсэн заалт нэмж оруулах;
11. Хуулийн 10.2.1-д "аймаг, нийслэл, хот хооронд шуудангийн илгээмж, хүргэх хуваарь, чиглэлийг ....... Засгийн газрын гишүүн гэж заажээ.
   **Зөвлөмж:** "аймаг, нийслэл, хот хооронд шуудангийн илгээмж, хүргэх хуваарь, чиглэлийг.............. "***Шуудангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага***" гэх;
12. Хуулийн 11 дүгээр зүйл. Шуудангийн сүлжээ гэж заажээ.
   **Зөвлөмж:** Шуудангийн сүлжээний *ашиглалт*. гэж найруулах;
13. **Зөвлөмж:** Хуулийн 6 дугаар бүлгийн "Шуудангийн илгээмжийн төрөл зэрэглэл, хүргэх хугацаа" гэсэн нэрийг "***Шуудангийн илгээмжийн төрөл, зэрэглэл***" гэж өөрчлөх;
14. Хуулийн 19 дүгээр зүйл. Шуудангийн илгээмжийн төрөл гэж заажээ.
   **Зөвлөмж:** Хуулийн 20 дугаар зүйлтэй нэгтгэн "***Шуудангийн илгээмжийн төрөл, зэрэглэл***" гэж найруулах;
15. Хуулийн 20.1-д "Шуудангийн илгээмжийг хүргэх хугацаагаар нь ердийн, шуурхай, буухиа гэж зэрэглэнэ" гэж заажээ.
   **Зөвлөмж:** "Шуудангийн илгээмжийг хүргэх хугацаагаар нь ердийн, буухиа гэж зэрэглэнэ" гэж найруулан хуулийн 19.1.4 дүгээр заалт болгон оруулж, хуулийн 20.2, 20.3, 20.4 дэхь заалтуудыг Монгол Улсын үндэсний стандартаар зохицуулах боломжтой учраас хасах;
16. Хуулийн 12.1-д "...шуудангийн илгээмжийг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан хугацаанд хүргэх үйлчилгээ хамаарна" гэж заажээ.
   **Зөвлөмж:** "***...Шуудангийн илгээмжийг тогтоосон хугацаанд хүргэх үйлчилгээ хамаарна***" гэж өөрчлөх;
17. **Зөвлөмж:** Хуулийн 21.1, 22.2 дахь заалтуудад "...Монгол Улсын олон улсын..." гэснийг "...***Монгол Улсын нэгдэн орсон олон улсын***..." гэж найруулах;
18. Хувьчлал явагдсан үед ДШХ-ны нэгдсэн сүлжээний өмнө хүлээх хариуцлагыг тодорхой болгох нь зүйтэй гэж үзлээ.
   **Зөвлөмж** :Үндсэн сүлжээ эзэмшигчийн үүрэгт 17'.2.3 дахь заалтаар "***Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцах***" гэж оруулах;

## НАЙМ. ДҮГНЭЛТ

Дээрх зөвлөмжийг үндэслэн 2003 онд батлагдсан "Шуудангийн тухай хууль"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахдаа дараах зүйлсийг анхаарах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Монгол шуудан ХК-ийн сүлжээний хувьчлалын асуудлыг шийдвэрлэхдээ хувьцааг зөвхөн хөрөнгийн биржээр дамжуулан иргэдэд нээлттэй худалдаж, нийт хувьцааны 51-ээс доошгүй хувийг төрийн өмч байхаар хуулийн төсөлд тусгах,

2. Шуудангийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн зүйл заалтуудад тусгагдсан Хяналт, хариуцлагын тухай асуудлыг УИХ-аар одоо батлагдах "Зөрчлийн тухай хууль"-тай харьцуулан, уялдуулах,

3. Захиргааны шийдвэр гаргах замаар шуудангаар Санхүүгийн үйлчилгээ эрхлэхэд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх, Дипломат шуудангийг төрийн тусгай шуудангийн бүрэлдэхүүнд багтаах, шивээсэн үсэгтэй (секограмм) номыг шуудангаар дамжуулах, УБ хотод шуудан тээврийн автомашиныг дугаарын хязгаарлалтад хамааруулахгүй байх асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх,

4. Дэлхийн шуудан холбооны 2016 оны Стамбулын стратегид багтсан Цахим худалдааг хөгжүүлэх чиглэлээр холбогдох судалгааг хийж эрх зүйн орчныг боловсронгуй болгоход анхаарч, хөтөлбөр боловсруулан ажиллах.

Хавсралт 1.

# ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө: | Холбогдох асуултууд | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх | **1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх** | | | |
| | 1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх | **Тийм** | | |
| | 1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх | **Тийм** | | |
| | 1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх | **Тийм** | | |
| | **1.2. Оролцоог хангах** | | | |
| | 1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх | **Тийм** | | |
| | 1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх | **Тийм** | | |
| | **1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага** | | | |
| | 1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх | **Тийм** | | |
| | 1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх | **Тийм** | | |
| | 1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх | **Тийм** | | |
| **2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх** | 2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх | **Тийм** | | |
| | 2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх | **Тийм** | | Монгол болон олон улсын хууль тогтоомжоор Шуудангаар явуулахыг хориглосон зүйлс, тээвэрлэхийг хориглосон |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **3. Эрх агуулагч** | 3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх | **Тийм** | | |
| | 3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх | | | |
| | 3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх | **Тийм** | | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд тэдэнд зориулагдсан баримт бичгийг дамжуулах тухай заалтыг мөрдөж байгаа |
| | 3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/ | **Тийм** | | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд тэдэнд зориулагдсан баримт бичгийг дамжуулах тухай заалтыг мөрдөж байгаа |
| **4. Үүрэг хүлээгч** | 4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх | **Тийм** | | |
| **5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх** | 5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх | **Тийм** | | БНҮҮ-т хамаарна |
| | 5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх | **Тийм** | | БНҮҮ-т хамаарна |

## ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| **Үзүүлэх үр нөлөө:** | **Холбогдох асуултууд** | **Хариулт** | | **Тайлбар** |
|---|---|---|---|---|
| **1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар** | 1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх | **Тийм** | | |
| | 1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан) | | **Үгүй** | |
| | 1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх | **Тийм** | | |
| **2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал** | 2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх | | **Үгүй** | |
| | 2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх | | **Үгүй** | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх | | **Үгүй** | |
| | 2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх | | **Үгүй** | |
| **3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал** | 3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх | | **Үгүй** | |
| | 3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх | **Тийм** | | |
| | 3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх | | **Үгүй** | |
| | 3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх | | **Үгүй** | |
| | 3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх | | **Үгүй** | |
| **4. Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал** | 4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх | | **Үгүй** | |
| **5. Өмчлөх эрх** | 5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх | **Тийм** | | Үндсэн сүлжээ эзэмшигч хувьцаат компаний хувьчлах асуудал хөндөгдөнө |
| | 5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх | **Тийм** | | Төр, хувийн хэвшлийн эзэмших хувьцааны харьцааг тогтоохоор тусгасан. |
| | 5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх | | **Үгүй** | |
| **6. Инноваци болон судалгаа шинжилгээ** | 6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх | **Тийм** | | |
| | 6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх | **Тийм** | | |
| **7. Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв** | 7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх | | **Үгүй** | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх | **Тийм** | | |
| | 7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх | | **Үгүй** | |
| | 7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх | | **Үгүй** | |
| **8. Тодорхой бүс нутаг, салбарууд** | 8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх | **Тийм** | | |
| | 8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх | | **Үгүй** | |
| | 8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх | **Тийм** | | Бичиг баримт болон бараа, материал солилцоход эерэг нөлөө үзүүлнэ. |
| **9.Төрийн захиргааны байгууллага** | 9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх | **Тийм** | | Улсын төсөвт орлого оруулна. |
| | 9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх | | **Үгүй** | |
| | 9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх | | **Үгүй** | |
| **10. Макро эдийн засгийн хүрээнд** | 10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх | **Тийм** | | Эерэг нөлөөтэй |
| | 10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх | **Тийм** | | Дэмжих |
| | 10.3.Инфляци нэмэгдэх эсэх | | **Үгүй** | |
| **11. Олон улсын харилцаа** | 11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх | **Тийм** | | |

## НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| **Үзүүлэх үр нөлөө:** | **Холбогдох асуултууд** | **Хариулт** | | **Тайлбар** |
|---|---|---|---|---|
| **1. Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл** | 1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх | **Тийм** | | |
| | 1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх | | **Үгүй** | |
| | 1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх | **Тийм** | | Эерэг нөлөөтэй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх | **Тийм** | | Эерэг нөлөөтэй |
| **2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх** | 2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх | **Тийм** | | Сайн |
| | 2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх | **Тийм** | | Хөдөлмөр, эрүүл ахуйн стандарттай |
| | 2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх | | **Үгүй** | |
| | 2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх | **Тийм** | | |
| | 2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх | | **Үгүй** | |
| **3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал** | 3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх | | **Үгүй** | |
| | 3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт | | **Үгүй** | |
| | 3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх | | **Үгүй** | |
| **4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун** | 4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх | | **Үгүй** | |
| | 4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | | **Үгүй** | |
| | 4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх | | **Үгүй** | |
| | 4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх | | **Үгүй** | |
| | 4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | | **Үгүй** | |
| **5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал** | 5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх | | **Үгүй** | |
| | 5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | | **Үгүй** | |
| | 5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, | | **Үгүй** | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх | | | |
| **6. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем** | 6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх | **Тийм** | | |
| | 6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх | | **Үгүй** | |
| | 6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | | **Үгүй** | |
| | 6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | | **Үгүй** | |
| | 6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх | | **Үгүй** | |
| **7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал** | 7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх | | **Үгүй** | |
| | 7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх | | **Үгүй** | |
| | 7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх | | **Үгүй** | |
| | 7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | | **Үгүй** | |
| **8. Соёл** | 8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх | **Тийм** | | Монгол маркийн Улсын фонд бүрдүүлж, хадгалалт, хамгаалах |
| | 8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх | | **Үгүй** | |
| | 8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх | | **Үгүй** | |

## БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| **Үзүүлэх үр нөлөө:** | **Холбогдох асуултууд** | **Хариулт** | | **Тайлбар** |
|---|---|---|---|---|
| **1. Агаар** | 1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | | **Үгүй** | |
| **2. Зам тээвэр, түлш, эрчим хүч** | 2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх | | **Үгүй** | |
| | 2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх | | **Үгүй** | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | |
| | 2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | | Үгүй | |
| **3. Ан амьтан, ургамлыг хамгаалах** | 3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх | | Үгүй | |
| | 3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх | | Үгүй | |
| | 3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх | | Үгүй | |
| | 3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх | | Үгүй | |
| **4. Усны нөөц** | 4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх | | Үгүй | |
| | 4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | | Үгүй | |
| | 4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх | | Үгүй | |
| **5. Хөрсний бохирдол** | 5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | |
| | 5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх | | Үгүй | |
| **6. Газрын ашиглалт** | 6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх | | Үгүй | |
| | 6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх | | Үгүй | |
| | 6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх | | Үгүй | |
| **7. Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг** | 7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх | | Үгүй | Аливаа нэгэн байгалийн баялаг ашигладаггүй. |
| | 7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх | | Үгүй | |

Хавсралт 2.

## Шуудангийн тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа

| № | Хуулийн заалтын дугаар | Хэрэгжсэн байдал | Гарч байсан хүндрэл | Бусад хууль тогтоомжтой хэрхэн холбогдсон | Бусад хууль тогтоомжтой зөрчилдсөн байдал | Өнөөгийн хэрэгцээ, хэрэглээнд нийцэж байгаа эсэх | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хуулийн зорилт | хэрэгжсэн | хуулийн заалт бүрэн хэрэгжихгүй, хязгаар нутагт шуудангийн тогтмол хүргэлт бараг байхгүй. хамрах хүрээний хувьд бусад салбарынхан төдийлэн хэрэгжүүлдэггүй | Харилцаа холбооны тухай хууль | | Шуудан ба шуудангийн үйлчилгээ | Харилцаа холбооны тухай хуультай зарим үг хэллэгийг нийцүүлэх Шуудангийн сүлжээнээс гадна үйлчилгээний талаар нарийн тусгах Тээвэр, гааль, хүнсний аюулгүй байдлын тухай хуультай зохицуулах талаар ярилцах |
| 2 | Шуудангийн тухай хууль тогтоомж | | | Харилцаа холбооны тухай хууль, Гаалийн тухай хууль, Иргэний тухай хууль, Авто тээврийн тухай хууль , Тусгай зөвшөөрлийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль | | | Хуулинд "Монгол улсын олон улсын гэрээ гэж бичигдсэн байгаа. Үүнийг "Монгол улсын нэгдэн орсон" гэж найруулах |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Хуулийн нэр томъёоны тодорхойлолт | 7.1.4, 9.1.3, 3.1.10 дах заалтууд нь бүсчлэлийн код, шуудангийн нэгдсэн кодуудын тодорхойлолтууд 3.1.5 буюу "боодол" гэсэн тодорхойлолтоос бусад нь сайн хэрэгжсэн | хүндрэл гараагүй | | 1. Гаалийн тухай хууль 3.1.1. "бараа" гэж гаалийн хилээр нэвтрүүлэх ачаа, тээш, эд юмс, валют, валютын үнэт зүйл, улс хоорондын шуудангийн илгээмж, бүх төрлийн эрчим хүч, мал, амьтан, ургамал зэрэг хөдлөх эд хөрөнгө болон энэ хуулийн 2. Харилцаа холбооны хуулийн 3.1.2 "сүлжээ" тодорхойлолт Шуудангийн хуулийн 3.1.2. "шуудангийн сүлжээ" өөр байдлаар туссан. Шуудангийн тухай хуулийн 3.1.11 - "үндсэн сүлжээ эзэмшигч" гэсэн тодорхойлолт зөрчигдсөн байна | 1. 3.1.5 болон 3.1.11 дэх заалтууд өнөөгийн нөхцө байдалд нийцэхгүй болсон 2. Дэлхийн Шуудан холбооны конвенци болон бусад баримт бичгүүдтэй уялдуулан нэр томъёог шинэчлэх талаар судлах шаардлагатай. | Шинээр цахим маркийн тухай оруулахдаа ДШХ-ны зөвлөмжийг үндэслэн оруулах |
| 4 | Монгол Улсын шуудан | | Шуудангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа | | Тусгай хэрэглээний шууданг хуулиар зохицуулах заалт оруулах | 4.2.3 дахь заалт өнөөгийн нөхцөлд нийцэхгүй болсон Жишээ нь: ТЗ-ын инкассатор | Тусгай шуудангийн тодорхойлолтыг өөрчлөх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Шуудангийн үйл ажиллагаанд баримтлах зорчим | сайн хэрэгжиж байгаа | | | Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйл.Хувь хүний нууцын төрөл 1.Хувь хүний нууц нь дараахь төрөлтэй байна: 1/захидал харилцааны нууц; - талаар тодорхой тусгах | нийцэж байгаа | |
| 6 | Засгийн газрын бүрэн эрх | Үндсэндээ хэрэгжсэн. Шуудангийн салбарт Төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн захиргааны төв байгууллага буюу Зам, тээвэр, аялал жуулчлалын яам, Улсын мэргэжлийн хяналтын газар,<br><br>Харилцаа, холбооны зохицуулах хороо гэсэн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлж байна. Шуудангийн салбарын үйлчилгээг боловсронгуй болгоход чиглэгдсэн арга хэмжээнүүдийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. | 6.1.2, 6.1.3 дахь заалтуудыг хэрэгжүүлэхэд хугацаа ихээр шаардагдаж байсан | 6.1.2,6.1.3 дах заалтууд өөрчлөгдсөн | | нийцэж байгаа | 1. Шуудангийн талаархи төрийн бодлого дэлхийн шуудан холбооны байгууллагын конвенцийн заалттай зарим асуудлыг нийцүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Шуудангийн асуудал эрхэлсэн Засгийн Газрын гишүүний бүрэн эрх | Үндсэндээ хэрэгжсэн | Мэдээлэл харилцаа холбооны чиг үүргийн төрийн захиргааны төв байгууллага байхгүйгээс эдгээр бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн тулд ЗГХЭГ-т хандах зэргээр илүү шат дамжлага үүсч, хугацаа алдаж байв. | | | нийцэхгүй байгаа Маркийн фондын зохицуулалтыг тодотгож нэмэх, Бусчлэлийн кодын нэршлийг нэг мөр болгох | Хот хоорондын шуудан хүргэлтийн хуваарь батлах, Маркийн сэдвийн төлөвлөгөөг батлах талаар тусгах шаардлагатай. Хэрэглэгчдийн хохирол барагдуулах журмыг батлах асуудлыг авч үзэх |
| 8 | Бүх шатны Засаг даргын эрх хэмжээ | Хэрэгжсэн | Шуудангийн үйлчилгээнд төдийлэн дэмжлэг үзүүлдэггүй. | | | | |
| 9 | ХХЗХ-ны эрх хэмжээ | Сайн хэрэгжсэн | харилцаа холбооны тухай хууль, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуульд шуудангийн асуудлыг бие даасан хуулиар зохицуулна гэсэн боловч эрх, хэм хэмжээний асуудал нь шуудангийн хуульд байдаггүй | | | Заалтуудыг өнөөгийн бий болсон нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэх | 1.Эрх бүхий байгууулагыг шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаарх мэдээллээр хангах<br>2. Хувийн шуудангийн байгууллагууд давуу эрхийн бус бүсийн тодорхой хэсэгт үйлчилгээ хүргэдэг байх. Ийм болзол хангавал тусгай зөвшөөрөл олгодог болох. Хэрэв зөвхөн давуу эрхийн бүсэд үйлчилгээ явуулбал бүх нийтийн үйлчилгээний санд илүү татвар хураамж төвлөрүүлдэг байх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Шуудангийн үйлчилгээ | Хэрэгжсэн | 10.2.1 дэх заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байсан | Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх: г/нутаг дэвсгэртээ харилцаа холбоог хөгжүүлэх, харилцаа холбооны үйлчилгээгээр хүн амыг хангах, шуудан солилцох, хүргэх хуваарь, чиглэлийг батлах; г/нутаг дэвсгэртээ харилцаа холбоог хөгжүүлэх, харилцаа холбооны үйлчилгээгээр хүн амыг хангах, шуудан солилцох, хүргэх хуваарь, чиглэлийг батлах; | | 10.2.1 -т өөрчлөлт оруулах /шуудангийн асуудал эрхэлсэн Төрийн Захиргааны байгууллага/ | |
| 11 | Шуудангийн сүлжээ | Хэрэгжсэн | 11.3 дахь заалт нь зохицуулалт хийхэд хүндрэлтэй байсан | | | 11.2 дэх заалтыг шуудангийн үндсэн сүлжээг хувьчлахтай холбогдуулан өөрчлөх | хувьчлалын талаар тусгах, бүрэн хувьчлахгүй, төрд 51 хувь үлдэхээр хуулинд тусгах. |
| 12 | Шуудангийн бүх нийтийн үйлчилгээ | хэрэгжсэн | 20 дугаар зүйлд заасан хүргэх үйлчилгээг хамарна | | | хувьчлалтай холбогдуулан өөрчлөх | БНҮҮ-н тодорхойлолтыг үйлчилгээний чанартай холбон тогтоодог болох |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | Электрон шуудангийн үйлчилгээ | Эхлэлийн төдий хэрэгжсэн | 1. Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Шуудангийн үндсэн сүлжээг өргөтгөн шинэчилж, мэдээллийн технологид суурилсан үйлчилгээг нэвтрүүлнэ" гэсэн зорилт тусгагдсан. 2. Цахим худалдаа, хүргэлтийн үйлчилгээ бүрэн тусгагдаагүй | | | | электрон гэдэг үгийг цахим гэх |
| 14 | Санхүүгийн үйлчилгээ | Дэлхийн шуудан холбооны 24 дүгээр их хурлаас батламжилсан "шуудангийн санхүүгийн үйлчилгээний нэгдсэн хэлэлцээр"-т Монгол Улс 2004 онд нэгдэн орсон. Мөн "Дэлхийн шуудан холбооны дүрмийн 7-р нэмэлт протокол"-д 2006 онд тус тус нэгдэн орсон ба бусад эрхзүйн хувьд энэхүү заалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрэн бүрдсэн. Хэрэгжилт 50% Эхлэлийн төдий хэрэгжсэн | Ерөнхий заалттай. | Банкны тухай хууль | Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 9.1.1. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн дүрмийн сан нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хэмжээнд хүрсэн" гэж энэхүү үйл ажиллагааг бие даасан хуулийн этгээд явуулахаар заасан байдаг. Тиймээс шуудангийн | | Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугээр зүйлийн 7.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 т заасан эрх хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй байдаг тул холбогдох хуулинд өөрчлөлт оруулах | | |
| 15 | Шуудангийн хэрэгсэл | хэрэгжсэн | | | | | Шуудангийн хэрэгслэлийг дэвшилтэт технологитэй уялдуулан тодорхойлох |
| 16 | Үйлчлэгчийн эрх, үүрэг | хэрэгжсэн | Ажил үүргээ гүйцэтгэж яваа шуудангийн үйлчилгээний автомашинаас орон нутгийн зам, гүүрээр өнгөрөн гарахад төлөх төлбөр хураамжаас чөлөөлөгдөх талаархи зохицуулалт байхгүй тул байнга төлбөр нэхэгддэг. | | Авто тээврийн тухай хууль 10.2.11.зөвхөн өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслээр улс, хот хоорондын нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх | орон нутгийн зам, гүүр, авто зогсоолд аливаа төлбөр, хураамжгүйгээр саадгүй нэвтрэх асуудлыг тусгах | Гэрээгээр шууданг хүргэдэг, гэрээт шуудангийн талаархи асуудлыг цэгцлэх, 16.3 .....үр ашигтай шуудангийн үйлчилгээ үзүүлэх гэдгийг тодорхой болгох Автозогсоолын төлбөр хураамж болон 1-р эгнээний асуудлыг хуулиар зохицуулж өгөх |
| 17 | Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг | хэрэгжсэн | | | | Хэрэглэгчдийн хохирол барагдуулах журмыг батлах гэж шинээр нэмэх | тухайн иргэн хориотой зүйлс илгээснээс үүссэн шууд ба шууд бус хохирлыг илгээгч хариуцах талаар судлан оруулах |
| 18 | Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн эрх үүрэг | Хэрэгжсэн | | | | 17.1.1 - өөрчлөлт оруулах /маркын фонд/ | Маркийн асуудлыг Шуудангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх үүрэгт хамруулах |
| 19 | Тарифийн хэмжээ | хэрэгжсэн | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | Шуудангийн илгээмжийн төрөл | хэрэгжсэн | | | | ДШХБ-ын конвенцитэй нийцүүлэх | |
| 21 | Шуудангийн илгээмжийн зэрэглэл, хүргэх хугацаа | Үндсэндээ хэрэгжсэн | Цаг, агаарын нөхцөл байдал, дэд бүтцийн хөгжлөөс хамаараад зарим тохиолдолд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байсан | | | | Шуудангийн илгээмжийн зэрэглэл хүргэх хугацаанаас хамаарсан ангиллыг илүү тодорхой, шинэ технологитэй уялдуулан зааж өгөх |
| 22 | Улс хоорондын шуудангийн илгээмж | хэрэгжсэн | | | | улс хоорондын шуудангийн илгээмжид гаалийн хяналт хийлгэх зорилгоор задлах,боох савлах,жигнэх, түүнчлэн, илгээмжийг хадгалах,илгээгч ээс нь хүлээн авах, хүлээн авагчид нь гардуулах үүргийг шуудангийн байгууллага хариуцах талаар тодотгох | |
| 23 | Шуудангийн үйл ажиллагаанд хэрэглэх хэл | хэрэгжсэн | | | | | |
| 24 | Хаяг тодорхойгүй шуудангийн илгээмж | хэрэгжсэн | | | | Шуудангийн илгээмж задлахад Гааль болон бусад холбогдох | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагууд оролцох эсэх | |
| 25 | Шуудангийн үйл ажиллагаанд хориглох зүйл | хэрэгжсэн | | | | | |
| 26 | Шуудангийн марк | Шуудангийн марк шуудангийн үнэт цаас бөгөөд төлбөрийн хэрэгсэл болж байна. үнэт цаас бөгөөд төлбөрийн хэрэгсэл болж байна. ЗТАЖ-ын сайдын 2006 оны 16 дугаар тушаалаар "Шуудангийн марк, үнэт цаас, үйлдвэрлэх, борлуулах журам"-ыг батлуулан, мөрдөж байна. | | | | шуудангийн илгээмж дээр " Монгол улс" гэсэн үгийг Монгол англи хэлээо бичиж, маркийн дээд хэсэгт "Соёмбо" үсэг байршуулсан, төгрөгөөр илэрхийлсэн нэрлэсэн үнэтэй маркийг наана гэж оруулах Цахим маркийн зохицуулалт оруулах | |
| 27 | Шуудангийн сүлжээний ашиглалт үйлчилгээнд тавих хяналт | Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг Улсын мэргэжилтийн хяналтын газрын улсын байцаагчид хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2004 онд Улсын мэргэжлийн хяналтын газраас хуулийн хэрэгжилтийг хангуулахад чиглэгдэнэ. | | | | | |
| 28 | Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага | | | | | Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэнэ. | Торгуулийн хэмжээ бага |

Хавсралт 3.

## Шуудангийн тухай хуулиар авсан санал асуулгын дүн

Шуудангийн тухай хуулийн тандан судалгааны ажлын хүрээнд шуудангийн үйлчилгээ эрхлэгчдээс авсан санал асуулгыг 2017 оны 03-р сарын 21-нд явууллаа. Уг санал асуулгыг нийт 3 бүлэг 26 асуултаар авсан байна.

Нэгдүгээр бүлгийн асуулгын дүн:

**Шуудангийн тухай хуулийн талаар**



1-р бүлэг асуултаар шуудангийн тухай хуулийн талаар тодруулж асуусан асуултуудыг багтааж авсан ба дараах саналуудыг тусгуулах шаардлагатай байна гэсэн тайлбарыг өглөө. Үүнд:

- Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдээс хураамж татвар авах асуудлыг компанийн орлогоос хамаарсан байдлаар тогтоох
- Улаанбаатар хот дотор шуудангийн машинуудыг дугаарын хязгаарлалтгүй 1-р эгнээгээр явах эрхтэй болгох

Хоёрдугаар бүлгийн асуулгын дүн:

## Шуудангийн үйлчилгээний талаар









Гуравдугаар бүлгийн асуулгын дүн:

## Төрөөс баримталж байгаа бодлогын талаар




3-р бүлэг асуултаар тодруулж асуусан асуултуудыг багтааж авсан ба дараах саналуудыг тусгуулах шаардлагатай байна гэсэн тайлбарыг өглөө. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл авдаггүй, хуульд харш үйл ажиллагаа явуулдаг газруудын хариуцлагын талаар
- Мөнгөн гуйвуулга хийх боломжтой болгох
- Газар шуудан чингэлэгээр ирж байгаа шуудангийн зохицуулалтын асуудлыг шийдвэрлэх
- Шуудангийн тарифийн асуудлыг ялангуяа хязгаар тогтоодог асуудлыг цэгцлэх
- Ашиглалтад орж байгаа орон сууц барилгад шуудангийн хайрцагтай байх боломжийг бүрдүүлэх
- Тухайн компани боломжоос шалтгаалан уян хатан хураамж төлөх нөхцлийг бүрдүүлэх
- Гаалийн болон бусад байгууллагатай зохицон ажиллах нөхцлийг бүрдүүлэх.

Хавсралт 4.

**Шуудангийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд хийсэн дүгнэлт**

Шуудангийн тухай хуулийн тандан судалгааны ажлын хэсгийн ажлын төлөвлөгөөний дагуу иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг орон даяар бүх аймаг, сум, нийслэл, дүүргүүдийг хамруулан нилэнхүй /түүврийн биш/ судалгааны аргаар явууллаа. Улсын хэмжээнд нийт 4585 хүнээс судалгаа авснаас 1705 хүн буюу 37.2 хувь нь УБ хотын, үлдсэн 62.8 хувь нь хөдөө орон нутгийн иргэд уг судалгаанд хамрагдсан байна. Судалгааны асуулт болон нэгтгэлийг хавсаргав.

Судалгааны асуулгын дараалын дагуу дүгнэлт хийв.

**Нэг. Ерөнхий мэдээлэл**

Энэ хэсэгт судалгаанд оролцогчдын нийгмийн бүлэг, боловсрол, нас, хүйс, байршил, орлогын хэлбэр ба эх үүсвэр гэсэн асуултууд орсон бөгөөд хариултаас үзэхэд судалгаанд хамрагдагсдын төлөөлөл хангалттай гэж үзэж болохоор байна. Тухайлбал, хот, хөдөөд адилхан эрэгтэй 47.45, эмэгтэй 52.55 хувийг эзэлж байна. Тогтмол орлоготой иргэд хотод 72.8, хөдөөд 63.7 хувь, тогтмол биш орлоготой хотод 25.7, хөдөөд 30.7 хувийг эзэлж байна. Орлогын эх үүсвэрийг авч үзвэл хотод цалин 56.2, тэтгэвэр 18.5, тэтгэмж 7.7, бусад 17.0 хувь, хөдөөд цалин 63.6, тэтгэвэр 11.6, тэтгэмж 4.2, бусад 14.7 хувийг тус тус эзэлж байна.

**Хоёр. Хандлага, хүлээлт, мэдээлэл**

**Та шуудангийн үйлчилгээг ямар давтамжтай авдаг вэ?** асуултанд өдөр бүр гэж хотод 45.4, хөдөөд 21.9 хувь, долоо хоног бүр гэж хотод 12.4, хөдөөд 17.1 хувь, шаардлага гарсан үед гэж хотод 14.1, хөдөөд 14.4 хувь хариулснаас үзвэл шуудангийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ хот, хөдөөгийн иргэдийн аль алинд нь, тэр тусмаа УБ хотын иргэдийн хувьд илүү байгааг харуулж байна.

**Танд шуудангийн салбарыг ойртуулбал үйлчилгээг ямар давтамжтай авах вэ?**_гэсэн асуултын хариултаас үзэхэд хөдөөгийн иргэдийн хэрэглээ тодорхой хувиар нэмэгдэхээр байна.

**Та цахим худалдааны үйлчилгээ шаардлагатай гэж үзэж байна уу?** гэсэн асуултанд "***тийм***" гэж хотын иргэдийн 63.2, хөдөөгийн иргэдийн 48.4 хувь хариулсан нь цахим худалдааны үйлчилгээ хот, хөдөөгүй хэрэгтэй байгааг харуулж байна.

**Та цахим мэдээлэл авах ямар түвшний мэдлэгтэй вэ?** гэсэн асуултанд "***сайн***" гэж хотод 55.3, хөдөөд 44.0 хувь, дунд гэж хотод 27.3, хөдөөд 35.0 хувь нь хариулсан нь хот, хөдөө ялгаагүй цахим худалдааны үйлчилгээг нэвтрүүлэхэд үйлчлүүлэгчид бэлэн байгааг харуулж байна.

**Та шуудангийн үйлчилгээний мэдээллийг ямар сувгаар авдаг вэ?** гэсэн асуултанд хот, хөдөө ялгаагүй 40 гаруй хувь нь интернет ба гар утас гэж

хариулсан нь цахим худалдааны үйлчилгээг нэвтрүүлэхэд үйлчлүүлэгчид бэлэн байгааг давхар баталж байна.

**Та дараах үйлчилгэээнээс аль үйлчилгээг нь авдаг вэ?** гэсэн асуултын хариултаас харахад хэвлэл захиалга, хүргэлт, илгээлт, албан бичиг, захидал гэсэн уламжлалт үйлчилгээнүүдийг судалгаанд оролцогчдын 10-36 хувь нь авдаг гэж хариулснаас үзэхэд эдгээр үйлчилгээнүүдийн хэрэглээ багагүй байгааг харуулж байна.

**Хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?** гэсэн асуултанд а) бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээллийг иргэдэд хүртээмжтэй болгох, б) ажилтны харилцааны соёлыг дээшлүүлэх, в) үйлчилгээний үнэ тарифыг бууруулах гэсэн хариулт давамгайлах хувь эзэлж байна.

**Гурав. Шуудангийн тухай хуулийн талаар**

**Та Шуудангийн тухай хууль байдгийг мэдэх үү?** гэсэн асуултанд мэдэхгүй гэж хотод 69.34, хөдөөд 58.52 хувь нь хариулжээ.

Тэрчлэн үйлчлүүлэгчийн мэдэж байвал зохих хэд хэдэн асуултад хот, хөдөөд ялгаагүй, тэр тусмаа хотод мэдэхгүй гэсэн хариулт ихэнх хувийг эзэлж байна.

**Дөрөв. Шуудангийн үйлчилгээний тухай**

**Та ямар шуудангийн байгууллагаар үйлчлүүлдэг вэ?** гэсэн асуултанд Монгол шуудан гэж хотод 90.57, хөдөөд 87.9 хувь, бусад шуудан гэж хотод 8.14, хөдөөд 6.5 хувь нь хариулсан нь хувийн шуудангийн компаниудын сүлжээ болон үйлчилгээний хүртээмж бага байгааг илтгэж байна.

**Та шуудангийн үйлчилгээг ямар хаягаар авдаг вэ?** асуултанд дараах байдлаар хариулсан байна.

| Төрөл | Хот | Хөдөө |
|---|---|---|
| 1. Гэрийн хаяг | 24.78 | 14.4567 |
| 2. Шуудангийн хаяг | 26.76 | 50.5525 |
| 3. Утасны дугаар | 13.69 | 9.39227 |
| 4. Байгууллагын хаягаар | 32.43 | 4.78821 |
| 5. Бусад хүний хаягаар | 0.123 | 7.91897 |
| 6. Бусад | 1.603 | 12.8913 |

Эндээс харахад хөдөөд шуудангийн хаяг, хотод байгууллагын хаягаар шуудангийн үйлчилгээг түлхүү авдаг байна. Түүнчлэн хот, хөдөөд гэрийн хаяг ба утасны дугаар мөн хэрэглэгдэж байна. Шуудангийн хайрцагны хүртээмжийн хувьд хотод 78.5, хөдөөд 95 хувь нь шуудангийн хайрцаггүй гэж хариулжээ.

Мөн зип кодыг ашигладаггүй ба мэдэхгүй гэж хот, хөдөөд ялгаагүй дийлэнх олонх нь, шуудангийн кодоо мэдэхгүй гэж 43 хувь нь, мэдэхийг хүсдэг гэж хөдөөд 22.2 хувь нь хариулсан байна.

**Тав. Шуудангийн үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ**

Доорх хүснэгтэд байгаа 12 үзүүлэлтээр судалгаанд оролцогсдын сэтгэл ханамжийн үнэлгээг 1-10 оноогоор, ач холбогдлын үнэлгээг мөн 1-10 оноогоор тус тус дүгнүүлж, судалгааг авсан.

Сэтгэл ханамжийн хувьд:

1-2.9 оноо маш муу,
3-4.9 оноо муу,
5-6.9 оноо дунд зэрэг,
7-8.9 оноо сайн,
9-10 оноо маш сайн гэсэн үнэлгээтэй дүйцнэ.

Харин үзүүлэлтийн ач холбогдлын хувьд:

1-2.9 оноо ач холбогдолгүй,
3-4.9 оноо бага зэргийн ач холбогдолтой,
5-6.9 оноо дунд зэргийн ач холбогдолтой,
7-8.9 оноо ач холбогдолтой,
9-10 оноо ач холбогдол ихтэй гэсэн үнэлгээтэй дүйцэх юм.

Судалгааны нэгтгэлийн өгөгдлүүдийг үндэслэн үзүүлэлт тус бүрийн дундаж оноог жигнэгдсэн дунджийн аргаар тооцоолж, хүснэгт 1-д иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг, хүснэгт 2-т үзүүлэлтийн ач холбогдлын үнэлгээг тус тус үзүүлэв.

Хүснэгт 1. Иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, дундаж оноогоор

| № | Үзүүлэлт | хот | хөдөө | дундаж |
|---|---|---|---|---|
| 1 | Шуудангийн үйлчилгээний шуурхай байдал | 8.36 | 9.05 | 8.7 |
| 2 | Үйлчилгээ авахад зарцуулсан хугацаа | 8.46 | 8.96 | 8.71 |
| 3 | Шуудан үйлчилгээний байршил | 8.47 | 9.05 | 8.76 |
| 4 | Үйлчилгээний талаарх мэдээллийн хангалт | 7.96 | 8.32 | 8.14 |
| 5 | Үйлчилгээг авахад хялбар байдал | 8.59 | 9.0 | 8.79 |
| 6 | Хэрэгтэй үйлчилгээг авсан түвшин | 8.73 | 9.11 | 8.92 |
| 7 | Үйлчлэгчийн бэлэн байдал | 8.65 | 9.29 | 8.97 |
| 8 | Авсан үйлчилгээтэй холбоотой хүндрэл, асуудал | 8.32 | 9.02 | 8.67 |
| 9 | Үйлчилгээний хариуцлага /баталгаа/ | 8.57 | 9.22 | 8.89 |
| 10 | Ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн ур чадвар | 8.58 | 9.12 | 8.85 |
| 11 | Ажилтнуудын харилцааны соёл, ёс зүй | 9.01 | 9.46 | 9.23 |
| 12 | Үйлчилгээний орчны тав тухтай байдал | 8.08 | 8.78 | 8.43 |
| | Нийт үзүүлэлтийн дундаж оноо | 8.48 | 9.03 | 8.75 |

Хүснэгт 1-ээс харахад шуудангийн үйлчилгээний талаархи иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ УБ хотод сайн /8.48 оноо/, хөдөө орон нутагт маш сайн /9.03 оноо/, улсын дунджаар сайн /8.75 оноо/ гэж гарсан байна.

Хүснэгт 2. Иргэдийн ач холбогдлын үнэлгээ, дундаж оноогоор

| № | Үзүүлэлт | хот | хөдөө | дундаж |
|---|---|---|---|---|
| 1 | Шуудангийн үйлчилгээний шуурхай байдал | 8.4 | 9.1 | 8.75 |
| 2 | Үйлчилгээ авахад зарцуулсан хугацаа | 8.46 | 9.19 | 8.82 |
| 3 | Шуудан үйлчилгээний байршил | 8.22 | 9.24 | 8.73 |
| 4 | Үйлчилгээний талаарх мэдээллийн хангалт | 7.8 | 8.59 | 8.19 |
| 5 | Үйлчилгээг авахад хялбар байдал | 8.72 | 9.05 | 8.88 |
| 6 | Хэрэгтэй үйлчилгээг авсан түвшин | 9.78 | 9.0 | 9.39 |
| 7 | Үйлчлэгчийн бэлэн байдал | 8.62 | 9.38 | 9.0 |
| 8 | Авсан үйлчилгээтэй холбоотой хүндрэл, асуудал | 8.17 | 9.2 | 8.68 |
| 9 | Үйлчилгээний хариуцлага /баталгаа/ | 9.02 | 9.32 | 9.17 |
| 10 | Ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн ур чадвар | 8.47 | 9.21 | .84 |
| 11 | Ажилтнуудын харилцааны соёл, ёс зүй | 9.39 | 9.28 | 9.33 |
| 12 | Үйлчилгээний орчны тав тухтай байдал | 8.42 | 8.76 | 8.59 |
| | Нийт үзүүлэлтийн дундаж оноо | 8.62 | 9.11 | 8.86 |

Хүснэгт 2-оос харахад дурьдсан үзүүлэлтүүдийг хотын иргэд ач холбогдолтой /8.62 оноо/, хөдөө орон нутгийн иргэд ач холбогдол ихтэй /9.11оноо/, улсын дунджаар ач холбогдолтой /8.86 оноо/ гэж үзсэн байна.

# ШУУДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

## Нэг.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар найруулах замаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг "Аргачлал батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал" /цаашид "Аргачлал" гэх/-д заасны дагуу дараахь үе шаттайгаар хийлээ:

1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2.Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4.Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

## Хоёр.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалд заасан 6 шалгуур үзүүлэлтээс дараахь 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо:

1.Зорилгод хүрэх байдал;
2.Ойлгомжтой байдал;
3.Харилцан уялдаа.

**"Зорилгод хүрэх байдал"** шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж байгаа байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэллээ. Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

**"Ойлгомжтой байдал"** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдэд ойлгомжтой, логик дараалалтай томьёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль

тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

**“Харилцан уялдаа”** шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг Аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцсон болно.

## Гурав. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООЖ, ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

**“Зорилгод хүрэх байдал”** шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ, шаардлагад хуулийн төслийн зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилт, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлалаас үзэхэд Монгол Улсын шуудангийн салбарыг уламжлалт үйлчилгээ бүхий өнөөгийн түвшнээс олон улсад өрсөлдөх чадвартай, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, түүний давуу талд тулгуурласан, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, найдвартай, хурдан шуурхай хүргэлтийг хийж чадах, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай шуудан болгон өөрчлөх асуудлыг Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгыг дэвшүүлжээ.

Үр нөлөөг үнэлэхэд тохирох шалгах хэрэгслийг даравхь байдлаар гаргав.

| Д/д | Шалгуур үзүүлэлт | Үр нөлөөг үнэлэх хэсэг | Тохирох шалгах хэрэгсэл |
|---|---|---|---|
| 1 | Зорилгод хүрэх байдал | Хуулийн төслийн зарим заалт | Зорилго, зорилгод хүрэхэд чиглэгдсэн хуулийн зохицуулалтуудад дүн шинжилгээ хийх |
| 2 | Ойлгомжтой байдал | Хуулийн төсөл бүхэлдээ | Ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу |
| 3 | Харилцан уялдаа | Хуулийн төсөл бүхэлдээ | Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу |

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараахь байдлаар үнэллээ.

### “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хуулийн зорилгод хүрэхэд чиглэгдсэн зохицуулалт болгон Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1, 2, 4, 6, 8 дахь заалт, 3 дугаар зүйлийн 1, 3, 8 дахь заалтуудыг сонголоо.

**Үр нөлөөг үнэлэхээр сонгосон хуулийн төслийн зохицуулалт**

| Хуулийн төслийн зүйл, заалт | Хуульд нэмэлт, өөрчлөлтөөр оруулж байгаа заалт |
|---|---|
| Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтаар хуулийн 3.1.4, 3.1.5 дахь заалтуудыг өөрчлөн найруулах | "3.1.4."захидал" гэж тодорхой этгээдэд хаягласан, дугтуйлсан болон дугтуйлаагүй гар бичмэл, хэвлэмэл баримт бичиг агуулсан шуудангийн илгээмжийг;<br><br>3.1.5."боодол" гэж тодорхой этгээдэд хаягласан, эд зүйлс агуулсан битүүмжлэгдсэн шуудангийн илгээмжийг;" |
| Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтаар хуулийн 3.1.10 дахь заалтыг өөрчлөн найруулах болон 4 дүгээр зүйлээр хуулийн 6.1.4 дэх заалтыг өөрчлөх | 3.1.10."шуудангийн нэгдсэн код" гэж шуудангаар үйлчлүүлэгчийн байршлыг тодорхойлсон тоо болон үсэг, тооны хосолсон илэрхийллийг;<br><br>6.1. Засгийн газар шуудангийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>6.1.4.шуудангийн нэгдсэн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журмыг батлах; |
| Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтаар хуульд 3.1.12 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь заалтаар хуульд 6.1.5 дахь заалт, мөн зүйлийн 6 дахь заалтаар хуульд $17^1$.2.3 дахь заалт тус тус нэмэх, төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтаар хуулийн 3.1.11 дэх заалтыг өөрчлөн найруулах | 3.1.11."шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч" гэж шуудангийн бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэгч байгууллагыг;<br><br>3.1.12."шуудангийн үндсэн сүлжээ" гэж төрийн өмчийн оролцоотой, бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэгч шуудангийн сүлжээг;<br><br>6.1. Засгийн газар шуудангийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>6.1.5.шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журам батлах;<br><br>$17^1$.2.Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч дараахь үүрэгтэй:<br><br>$17^1$.2.3.Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийг хариуцах. |
| Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтаар хуульд 19.2 дахь хэсэг нэмэх, 3 дугаар зүйлийн 6 дахь заалтаар хуулийн 14.1 дэх хэсгийг өөрчлөн найруулах | 19.2.Шуудангийн илгээмжийг хүргэх хугацаагаар нь ердийн, буухиа гэж зэрэглэнэ.<br><br>14.1.Үйлчлэгч нь Зохицуулах хорооноос баталсан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын дагуу захиалгат илгээмжийн худалдаа эрхэлж болно. |
| Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтаар хуульд 25.3 дахь хэсэг нэмэх | 25.3.Шуудангийн маркийн хадгалалт, хамгаалалт, хөгжилд зарцуулах санг үүсгэх ба сангийн удирдлага, зохион байгуулалтыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна. |
| Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтаар хуульд 9.1.4-9.1.6 дахь заалт нэмэх | Зохицуулах хорооны бүрэн эрх:<br><br>9.1.4.хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, зохицуулалтын баримт бичиг болон холбогдох журам батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;<br><br>9.1.5.шуудангийн харилцан холболтын журмыг баталж, хэрэгжилтийг хангуулах;<br><br>9.1.6.шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх; |

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтаар хуулийн захидал, боодол, шуудангийн нэгдсэн код гэсэн томьёог өөрчлөн найруулах, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтаар хуулийн 19 дүгээр зүйлд Шуудангийн илгээмжийг хүргэх хугацаагаар нь ердийн, буухиа гэж зэрэглэх тухай 2 дахь хэсэг нэмэх, 3 дугаар зүйлийн 6 дахь заалтаар хуулийн 14.1 дэх хэсгийг өөрчлөн найруулж, Зохицуулах хорооноос баталсан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын дагуу хуулийн этгээд захиалгат илгээмжийн худалдаа эрхэлж болохоор тусгасан нь хуулийн төслийн үзэл баримтлалын мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, түүний давуу талд тулгуурласан, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, найдвартай, хурдан шуурхай хүргэлтийг хийж чадах шуудангийн үйлчилгээг бий болгох хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Түүнчлэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт, 3 дугаар зүйлийн 3 дахь заалтаар "үндсэн сүлжээ" болон "үндсэн сүлжээ эзэмшигч"-ийн тодорхойлолтыг бий болгож, төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтаар Засгийн газар шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журам батлах, мөн зүйлийн 6 дахь заалтаар хуульд $17^1$.2.3 дахь заалт нэмж, шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийг хариуцахаар, 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтаар хуульд 25.3 дахь хэсэг буюу шуудангийн маркийн хадгалалт, хамгаалалт, хөгжилд зарцуулах санг үүсгэх, сангийн удирдлага, зохион байгуулалтыг төрийн захиргааны байгууллага хариуцах тухай зохицуулалт нэмэхээр тусгасан нь хуулийн үзэл баримтлалд төрийн мэдлийн үндсэн сүлжээ эзэмшигчийн статусыг тодорхой болгох, үндсэн сүлжээний эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд шуудангийн маркийн үнэ, эзэмшил, эрхлэн гаргах асуудлыг тодорхой болгох зэрэг хэрэгцээ, шаардлагыг хангасан байна гэж үзлээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтаар хуульд 9.1.4-9.1.6 дахь заалт нэмэх, өөрөөр хэлбэл, Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрхэд хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, зохицуулалтын баримт бичиг болон холбогдох журам батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих, шуудангийн харилцан холболтын журмыг баталж, хэрэгжилтийг хангуулах, шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх эрхийг нэмсэн нь шуудангийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн үйлчилгээг шуурхай болгох, шуудангийн салбарын хууль, эрх зүйн орчныг тодорхой болгох практик шаардлагыг хангаж байна.

Иймд хуулийн төслийн сонгож авсан заалтууд нь Шуудангийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд заасан хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг хангасан, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгод хүрэх боломжтой зохицуулалтууд болжээ гэж үзлээ.

## “Ойлгомжтой байдал”шалгуур үзүүлэлтийн хүрээнд

| Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага | |
|---|---|
| **Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт** | **Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал** |
| 29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх; | Шаардлагад нийцсэн. |
| 29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх; | Шаардлагад нийцсэн. |
| 29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх; | Шаардлагад нийцсэн. |
| 29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх; | Шаардлагад нийцсэн |
| 29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх; | Шаардлагад нийцсэн. |
| 29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх; | Шаардлагад нийцсэн. |
| 29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх; | Шаардлагад нийцсэн. |
| 29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам; | Шаардлагад нийцсэн. |
| 29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт; | Шаардлагад нийцсэн. |
| 29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх; | Шаардлагад нийцсэн. |
| 29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана. | Ийм зүйл шаардлагагүй. |
| **Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага** | |
| 30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх; | Шаардлагад нийцсэн. |
| 30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх; | Шаардлагад нийцсэн. |
| 30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих; | Шаардлагад нийцсэн. |
| 30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх; | Шаардлагад нийцсэн. |
| 30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх. | Шаардлагад нийцсэн. |

## “Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

| Д/д | Асуулт | Хариулт буюу дүн шинжилгээ |
|---|---|---|
| 1 | Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх; | Нийцсэн. |
| 2 | Хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх | Төсөлд байхгүй. |
| 3 | Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх; | Нийцсэн. |
| 4 | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх; | Нийцсэн. |
| 5 | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх; | Давхардаагүй. |
| 6 | Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх; | Тусгасан. |
| 7 | Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх; | Орхигдуулаагүй. |
| 8 | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх; | Тусгаагүй. |
| 9 | Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх; | Энэ асуудлыг тусгах шаардлагагүй. |
| 10 | Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх; | Ийм зохицуулалт шаардлагагүй. |
| 11 | Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх; | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд уг зохицуулалт байгаа, нэмж тусгах шаардлагагүй. |
| 12 | Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх; | Тусгаагүй. |
| 13 | Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх; | Ийм зохицуулалт шаардлагагүй. |
| 14 | Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх; | Ийм зохицуулалт шаардлагагүй. |
| 15 | Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх; | Ийм зохицуулалт шаардлагагүй. |
| 16 | Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх. | Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулна. |

## Дүгнэлт, зөвлөмж

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг Аргачлалын дагуу тооцож, дараахь дүгнэлтийг гаргаж байна.

1.Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь сонгосон шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг хангасан, хуулийн төслийн томьёолол нь ойлгомжтой, хоёрдмол утга санаагүй, тодорхой, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль

тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалттай давхардаагүй, зөрчилдөөгүй гэж дүгнэж байна.

2.Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага болон хуулийн төслийн уялдаа холбоо хангагдсан байна гэж үзлээ.

Ийнхүү Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа тул олон нийтээр хэлэлцүүлэн Засгийн газарт санал авахаар хүргүүлэх зөвлөмжийг санал болгож байна.

---oOo---

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗАР
WWW.ICT.MN

# ШУУДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

**УЛААНБААТАР ХОТ**
**2018 ОН**

## ШУУДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ СУДАЛГАА

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал (цаашид "аргачлал" гэх)-ын дагуу урьдчилсан байдлаар тооцов.

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр зохицуулж байгаа харилцаа өмнө нь тус хуулиар болон бусад хууль, эрх зүйн актаар зохицуулагдаж байсан бөгөөд нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь бүгд шинээр зохицуулагдаж байгаа харилцаа биш юм. Мөн Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохицуулах байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхой тусгах шаардлагатай болсон тул хуулийн төслөөр дэлгэрүүлэн хуульчилсан болно.

Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан хуулийн зүйл, заалтуудыг хавсралт 1-д үзүүлсэнчлэн шинээр бий болгож байгаа үүргийн хүрээнд иргэн, хуулийн этгээд болон төрийн байгууллагад зардал үүсгэх боломжтой 18 хуулийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлыг тус тус тооцсон.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримталсан болно. Үүнд:

- гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг бодитоор тогтоох;
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

### НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Хуулийн этгээдийн зардлыг тооцох ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулсан. Үүнд:

1.1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
1.2. Зардлыг тооцох;
1.3. Тоон үзүүлэлтийг тооцох;
1.4. Нийт зардлын дүнг тооцож гаргах;
1.5. Хялбарчлах боломжийг шалгах;
1.6. Нэмэлт зардлыг тооцох.

**Нэгдүгээр үе шат:** Аргачлалын 2.3-т хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоохдоо хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг нэг бүрийг тогтоохоор дурдсан байна.

Гүйцэтгэх үүрэг гэдгийг тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг ойлгохоор тусгажээ. /Үүнд бүх төрлийн өргөдөл, хүсэлт, маягт бөглөх, статистик тоо мэдээ өгөх, бүртгүүлэх, нөхөн олговор, төрөөс тусламж, дэмжлэг, зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл гаргах, зөвшөөрөл хүсэх гэх мэт үүрэг хамаарна./

Аргачлалд зардлыг тооцохын тулд ажилтны ажлын хөлс, мэдээлэл бэлтгэн гаргахтай холбогдуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлийн хугацааг нэг бүрчлэн тодорхойлох шаардлагатай:

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн хувьд дараах хуулийн заалтуудыг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүргийг тодорхойлж, зардлыг тооцов:

Хүснэгт 1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг

| Хуулийн заалт | Гүйцэтгэх үүрэг |
|---|---|
| 14.1.Үйлчлэгч нь Зохицуулах хорооноос баталсан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын дагуу захиалгат илгээмжийн худалдаа эрхэлж болно. | - Тусгай зөвшөөрөл шинээр авах, хугацааг сунгах, хүчингүй болгуулах<br>- Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах |
| 16.3.3.Шуудангийн үйлчилгээ үзүүлэхээр тогтоосон хугацаа, чанар нь үндэсний стандартыг хангаж буй тухай мэдээллийг үйлчлүүлэгчид гаргаж өгөх буюу мэдээлэх; | - Шуудангийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон стандартуудыг худалдаж авах<br>- Зохицуулах хороонд тайлан гаргаж өгөх |

**Хоёрдугаар үе шат:** Гүйцэтгэх үүрэг тус бүрийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцох

Хуулийн заалт бүрийн хувьд гүйцэтгэх үүргийг тогтоож, үүргийг хэрэгжүүлэхэд хийгдэх стандарт үйл ажиллагаа тус бүрээр гарган түүнд зарцуулах хугацааг тодорхойлов.

Хуулийн төсөлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд хийгдэх ажиллагааг алхам тус бүрээр тодорхойлон түүнд зарцуулах хугацааг нэг бүрчлэн ажиглалт хийсний үндсэн дээр тодорхойлсон дундаж хугацааг ашигласан болно.

Хүснэгт 2. Хуулийн этгээдээс гарах зардлын тооцоо

| **Хуулийн заалтын дугаар** | **Гүйцэтгэх үүрэг** | **Нэгж зардал** | **Тоон үзүүлэлт** | **Дүн /төг/** | **Тайлбар** |
|---|---|---|---|---|---|
| 14.1 | Тусгай зөвшөөрөл шинээр авах, хугацааг сунгах, хүчингүй болгуулах | 317,490 | 9 | 2,857,410 | Жилд 9 байгууллага тусгай зөвшөөрөл шинээр авдаг. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | Хавсралт 2.1 |
| | Хугацаа сунгах | 317,490 | 3,96 | 1,257,260 | 3 жилд нэг удаа сунгадаг бөгөөд жилд 9 компани сунгуулдаг. |
| 16.3.3 | Шуудангийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон стандартуудыг худалдаж авах | - | - | - | Стандартуудын үнэлгээг урьдчилан тооцох боломжгүй тул зардал тооцоогүй. |
| | Тайланг холбогдох байгууллагад гаргаж өгөх | 35,910 | 108 | 3,878,280 | 59 тусгай зөвшөөрөл эзэмшигчээс жилд 2 удаа үйлчлэгч байгууллагууд ХХЗХ-нд тайлан өгдөг. Хавсралт 2.2 |
| | **Нийт гарах зардал** | | | **7,992,950** | |

**Гуравдугаар үе шат:** Тоон үзүүлэлтийг тохиолдлын болон давтамжийн тоо ашиглан тооцох

Тохиолдлын тоо буюу арга хэмжээг нэг жилд хэдэн удаа хийгддэг давтамжийг гаргахдаа Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015-2017 оны тоо баримтыг судалгаа болгон ашиглав.

Хүснэгт 3. Тоон үзүүлэлт

| Тохиолдол | 2015 он | 2016 он | 2017 он | Тохиолдлын тоо | Давтамжийн тоо | Тоон үзүүлэлт |
|---|---|---|---|---|---|---|
| Тусгай зөвшөөрөл шинээр хүссэн | 10 | 5 | 12 | 9 | 1 удаа | 9 |
| Тусгай зөвшөөрөл сунгасан | 3 | 17 | 15 | 12 | 3 жилд 1 удаа | 3,96 |
| Тусгай зөвшөөрөл цуцлагдсан | 3 | 6 | 7 | 5 | 1 удаа | 5 |
| Тусгай зөвшөөрлийн тоо | 60 | 52 | 66 | 59 | | 59 |

Харилцаа холбооны зохицуулах хорооны гаргасан статистикаар шуудангийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтаны 1 сарын дундаж цалин 600,000 төгрөг байна. Үүнийг ажлын 22 өдрөөр тооцвол нэг минутад ноогдох ажлын хөлс 56,81 төгрөг болно.

**Дөрөвдүгээр үе шат:** Нийт зардлын дүнг хүснэгт 2-д тооцсон болно.

**Тавдугаар үе шат:** Хялбарчлах боломжийг шалгахдаа өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг

бууруулах, дарамт, ачааллыг багасгах арга замыг асуултад хариу авах замаар тодорхойлно.

Хүснэгт 4. Хуулийн этгээдийн үүргийг хялбарчлах боломжийн асуулга

| Д/д | Асуулт | Хариулт | Тайлбар |
|---|---|---|---|
| 1. | Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх | Боломжгүй | Шуудангийн үйлчилгээний тоо, хамрах хүрээ нэмэгдэж байгаа тул бууруулах боломжгүй. |
| 2. | Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх | Боломжгүй | Хуулинд заасан мэдээллийг авдаг тул бууруулах боломжгүй. |
| 3. | Мэдээллийн цахимаар хүргүүлэх боломжтой эсэх | Боломжтой | Мэдээллийг цаасаар мөн цахимаар авах боломжтой. |
| 4. | Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх | Боломжгүй | Хууль тогтоомжийн дагуу хүргүүлдэг тул боломжгүй. |

**Нэмэлт зардал**: Хуулийн төслийн хүрээнд өөр бусад /нэмэлт/ зардал шаардсан зүйл байхгүй байна.

**Дүгнэлт :** Шуудангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 болон 16.3.3 дахь заалтыг хэрэгжүүлэхэд нийт **7,992,950** (долоон сая есөн зуун ерэн хоёр мянга есөн зуун тавь) төгрөгийн зардал гарахаар тооцов.

Хуулийн этгээдтэй холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа хуулийн заалтууд нь бүгд шинээр зохицуулагдаж байгаа харилцаа биш, одоо ч мөрдөж байгаа тул үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал, ажлын ачаалал үүсэхгүй гэж тооцож байна.

## ХОЁР. ИРГЭНИЙ ЗАРДЛЫГ ТООЦОХ

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тусгагдсан иргэнтэй холбоотой хуулийн заалтууд нь хавсралт 1-д үзүүлсэнчлэн найруулгын шинж чанартай өөрчлөлтүүд тул нэмэлт зардал тооцогдохгүй болно.

## ГУРАВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫГ ТООЦОХ

***Төрийн захиргааны байгууллагын буюу Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас гарах зардлыг тооцох***

Төрийн байгууллагын зардлыг тооцох ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулсан болно. Үүнд:

3.1. Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
3.2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
3.3. Гарах зардлыг урьдчилан тооцох;

3.4. Зардлыг нэгтгэн тооцох;
3.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

**Нэгдүгээр үе шат:** Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан өөрчлөлтүүд нь бүгд шинээр зохицуулах харилцаа биш бөгөөд өмнө нь тус хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагдаж байсан болно.

Мөн Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг нэг бүрийг дэлгэрэнгүй байдлаар хуульчлан оруулсан.

Иймд аргачлалын дагуу хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслөөр шинээр бий болгож байгаа дараах үүргийн хүрээнд гарах зардлыг тооцов. Хавсралт 1-д ангилсаны дагуу Засгийн газар болон төрийн захиргааны байгууллагын хариуцах чиг үүргийн хүрээнд дараах хуулийн заалтуудтай холбоотой гарах зардлыг тооцсон болно.

Хүснэгт 5. Засгийн газар болон Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх үүрэг

| Хуулийн заалт | Гүйцэтгэх үүрэг |
|---|---|
| **Засгийн газар** | |
| 6.1.4.Шуудангийн нэгдсэн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журмыг батлах | - Шуудангийн нэгдсэн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журам батлах |
| 6.1.5.Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийг сонгох, гэрээ байгуулах, хяналт тавих журам батлах | - Журам батлах |
| **Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага** | |
| 6.1.4.Шуудангийн нэгдсэн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журмыг батлах | - Журам боловсруулах<br>- Журмын хэрэгжилтийг хангуулах |
| 6.1.5.Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийг сонгох, гэрээ байгуулах, хяналт тавих журам батлах | - Журам боловсруулах<br>- Журмын хэрэгжилтийг хангуулах |
| 7.1.1.бүх нийтийн үйлчилгээний төрлийг Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн тогтоох | - Холбогдох саналыг үндэслэн тогтоолын төсөл бэлдэх, батлах<br>- Хөрөнгө төвлөрүүлэлтэд хяналт тавих |
| 7.1.3.Үйлчлэгч болон шуудангийн илгээмж тээвэрлэгч этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах журам боловсруулж, хэрэгжүүлэх | - Холбогдох судалгаа хийх<br>- Журам боловсруулах, батлах<br>- Журмын хэрэгжилтийг хангуулах |
| 7.1.5.Шуудангийн марк, үнэт цаасыг үйлдвэрлэх бодлого боловсруулах, | - Судалгаа хийх<br>- Журам боловсруулах, батлах |

| | |
|---|---|
| шуудангийн марк, үнэт цаасны улсын фондыг баяжуулах, хадгалах, хамгаалах, хяналт тавих журам батлах | - Маркийн улсын фондын хадгалалт, хамгаалалтын зардлыг тооцох |
| 7.1.8.Олон улсын шуудангийн байгууллагад Монгол улсыг төлөөлөх, олон улсын болон бүсийн хуралд бэлтгэх, оролцохтой холбогдсон болон олон улсын гишүүн орнуудаас урьдчилан гаргасан санал, дүгнэлт, судалгааны үр дүнг судлах ажлыг зохион байгуулах. | - Судалгаа хийх, санал боловсруулах<br>- Хуралд бэлтгэх, хуралд оролцох |

**Хоёрдугаар үе шат:** Үүрэг буюу ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох.

Хуулийн заалт бүрийг гүйцэтгэх үүргээр нь задлан, үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагааг алхам тус бүрээр гарган түүнд зарцуулах хугацааг тодорхойлов (Хавсралт 1.1 ба 1.2).

Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг хувьд бодлого, зохицуулалтын баримт бичиг боловсруулах бөгөөд хуулийн төсөл батлагдсаны дараа эдгээр ажил, үйлчилгээг хамгийн багадаа жилд 1 удаагийн давтамжтай хийнэ гэж тооцов. Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг гаргав.

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр Засгийн газар болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана.

Засгийн газрын ажлын хөлсийг тогтоохдоо Засгийн газрын референт нь төрийн захиргааны албан хаагчийн цалингийн ТЗ зэрэглэлд хамаардаг тул "Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ"-ний ТЗ-9 зэрэглэлээр дундаж цалингийн хэмжээг тооцож, холбогдох нэмэгдлүүдийг тусган нэг референтийн дундаж цалинг 900 000 төгрөг байхаар тооцов.

Хүснэгт 6. Цалингийн зэрэглэл хэмжээ

| Албан тушаалын зэрэглэл | 1 | 2 | 3 | 4 | 5 | Сарын дундаж цалин |
|---|---|---|---|---|---|---|
| ТЗ-9 | 691610 | 735470 | 779338 | 821779 | 864211 | 778481.6 |

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлд ердийн нөхцөлд ажлын цагийг 7 хоногт 40 цагаас, нэг өдрийн ажлын цагийг 8 цагаас

илүүгүй байхаар зохицуулсан байдаг. Үүнээс харахад нэг ажилтан нэг сард ажлын 22 өдөр /22*8=176 цаг, 176*60=10560 минут/ ажилладаг байна.

Хүснэгт 7. ЗГХЭГ-ын референтийн ажлын хөлсийг цаг, минутаар

| Үндсэн цалин | Ажиллах хугацаа | Ажлын хөлс |
|---|---|---|
| 900 000 | 176 цаг | 5 131 төг /цагт/ |
| 900 000 | 10560 минут | 85,2 төг /минут/ |

Хүснэгт 8. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас гарах зардлын тооцоо

| Хуулийн заалтын дугаар | Гүйцэтгэх үүрэг | Нэгж зардал | Тоон үзүүлэлт | Дүн /төг/ | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 6.1.4. | Журам батлах | 459000 | 1 | 459000 | Хавсралт 2. |
| 6.1.5. | Журам батлах | 459000 | 1 | 459000 | |
| | **Нийт** | | | **918000** | |

Хүснэгт 9. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас гарах зардлын тооцоо

| Хуулийн заалт | Гүйцэтгэх үүрэг | Нэгж зардал | Тоон үзүүлэлт | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 6.1.4. | Судалгаа хийх | 269040 | 1 | 269040 | Хавсралт 3.1 |
| | Журам боловсруулах | 202920 | 1 | 202920 | |
| | Хэрэгжилтийг хангуулах | 107920 | 1 | 107920 | |
| 6.1.5. | Судалгаа хийх | 269040 | 1 | 269040 | Хавсралт 3.1 ба 3.2 |
| | Журам боловсруулах | 202920 | 1 | 202920 | |
| | Хэрэгжилтийг хангуулах | 107920 | 1 | 107920 | |
| 7.1.1. | Тогтоол батлах | 38380 | 1 | 38380 | БНҮҮС-нд хөрөнгө төвлөрүүлэлт одоо хийгддэг тул зөвхөн тогтоол гаргахад зардал тооцогдоно. |
| | Тогтоолын дагуу БНҮҮС-ийн хөрөнгө төвлөрүүлэлтэд хяналт тавих | 107920 | 1 | 107920 | |
| 7.1.3. | Судалгаа хийх | 269040 | 1 | 269040 | Хавсралт 3.1 |
| | Журам боловсруулах, батлах | 241300 | 1 | 241300 | |
| | Хэрэгжилтийг хангуулах | 107920 | 1 | 107920 | |
| 7.1.5. | Судалгаа хийх | 269040 | 1 | 269040 | Уг улсын фонд нь одоо үндсэн сүлжээний харъяанд |
| | Журам боловсруулах | 202920 | 1 | 202920 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | маркийн улсын фондын хадгалалт, хамгаалалтын зардлыг тооцох | - | - | - | ажилладаг тул зардал нэмэгдэхгүй. |
| 7.1.8. | Судалгаа хийх, санал боловсруулах | 471960 | 1 | 471960 | Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэн нарийвчилж оруулсан заалт тул нэмэлт зардал гарахгүй бөгөөд байнга хийгдэж байдаг. |
| | Хуралд бэлтгэх, хуралд оролцох | - | - | - | Олон улсын хуралд 4 жилд нэг удаа оролцдог тул тухайн үед зардал бодогддоно. |
| | **Нийт дүн** | | | **2599200** | |

Хүний нөөцийн зардалд үндсэн цалингаас гадна бусад нэмэгдэл, төрөөс олгодог урамшуулал зэргийг оруулан тооцохоор аргачлалд заасан тул Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын нэг албан хаагчийн дундаж цалинг сарын 800,000 төгрөг байхаар тооцож ажлын 22 өдөрт хуваахад минутад ноогдох ажлын хөлс нь 76 төгрөг болно.

**Гуравдугаар үе шат:** Зардлын тооцоог хүний нөөцийн, материаллаг, бусад гэсэн зардлын бүрэлдэхүүнд хувааж, тэдгээрийн нийлбэрийг гаргасны үндсэн дээр тогтооно.

Материаллаг зардлыг тооцохдоо Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2017 оны тоо баримтыг үндэслэсэн бөгөөд нэг албан хаагчид оногдох мөнгөн дүнгээр 1,292,745 төгрөг байна.

**Дөрөвдүгээр үе шат:** Нийт дүнг тооцоолох бөгөөд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардлын нийлбэрээр нийт зардлыг тооцон гаргана.

Хүний нөөцийн зардал + Материаллаг зардал = **Нийт зардал**

918,000 төгрөг + 2,599,200 төгрөг + 1,292,745 төгрөг = **4,809,945 төгрөг**

**Тавдугаар үе шат:** Хялбарчлах боломжийг шалгахдаа өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах, дарамт, ачааллыг багасгах арга замыг асуултад хариу авах замаар тодорхойлно:

Хүснэгт 10. Төрийн байгууллагын үүргийг хялбарчлах боломжийн асуулга

| Д/д | Асуулт | Хариулт | Тайлбар |
|---|---|---|---|
| 1. | Боловсруулан, батлах журмын тоог багасгах | Боломжгүй | Хуулиар үүрэгжүүлсэн. |

| | | | |
|---|---|---|---|
| 2. | Судалгааны мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх | Боломжгүй | Судалгаа ач холбогдолгүй болно. |
| 3. | Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх | Боломжтой | Өмнө нь хийгдэж байсан ажлууд бөгөөд Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэн дэлгэрэнгүй байдлаар хуульчлагдсан. |
| 4. | Зарим баримт бичгийг боловсруулах хугацааг багасгах боломжтой эсэх | Боломжтой | |
| 5. | Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх | Боломжгүй | Мэдээллийн хүртээмж буурна. |

**Дүгнэлт:**

Шуудангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 болон 6.1.5, мөн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, 7.1.5 болон 7.1.8 дахь заалтуудыг хэрэгжүүлэхэд нийт **4,809,945** (дөрвөн сая найман зуун есөн мянга есөн зуун дөчин тав) төгрөгийн зардал гарахаар тооцов.

Дээрх зардал тооцогдсон хуулийн заалтын хүрээнд хийгддэг үйл ажиллагаанууд нь Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар дээр одоо хийгддэг бөгөөд Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэх зорилгоор илүү нарийвчлан хуульчилсан юм. Иймд хүснэгт 8 болон 9-д харуулсан тооцоогоор гарсан зардал нь одоо мөрдөж байгаа зардалд багтах учраас улсын төсөвт нэмэлт зардал үүсгэхгүй болно.

***Зохицуулах байгууллагын буюу Харилцаа холбооны зохицуулах хорооноос гарах зардлыг тооцох***

Зохицуулах байгууллагын зардлыг тооцох ажлыг төрийн байгууллагын зардал тооцохтой адил үе шаттайгаар зохион байгуулсан.

**Нэгдүгээр үе шат:** Зохицуулах байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох

Аргачлалын дагуу хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд шинээр оруулж байгаа дараах үүргийн хүрээнд гарах зардлыг тооцов. Хавсралт 1-д ангилсаны дагуу зохицуулах байгууллагын хариуцах чиг үүргийн хүрээнд дараах хуулийн заалтуудтай холбоотой гарах зардлыг тооцсон болно.

Хавсралт 1-д ангилсаны дагуу Зохицуулах байгууллагын хариуцах чиг үүргийн хүрээнд дараах хуулийн заалтуудтай холбоотой гарах зардлыг тооцсон болно.

Хүснэгт 11. Зохицуулах байгууллагын гүйцэтгэх үүрэг

| Хуулийн заалт | Гүйцэтгэх үүрэг |
|---|---|
| **Зохицуулалтын байгууллага** | |
| 3.1.4.“захидал” гэж тодорхой этгээдэд хаягласан, дугтуйлсан болон дугтуйлаагүй гар бичмэл, хэвлэмэл баримт бичиг агуулсан шуудангийн илгээмжийг; | - Стандарт боловсруулах |
| 3.1.5.“боодол” гэж тодорхой этгээдэд хаягласан эд зүйлс агуулсан, битүүмжлэгдсэн шуудангийн илгээмжийг; | - Стандарт боловсруулах |
| 3.1.8"шуудангийн хайрцаг" гэж шуудангаар үйлчлэгчээс шуудангийн илгээмжийг хүргэхэд ашиглах зориулалтаар тодорхой цэгт байрлуулсан савыг; | - Стандарт боловсруулах |
| 3.1.10.“шуудангийн нэгдсэн код” гэж шуудангаар үйлчлүүлэгчийн байршлыг тоогоор, эсхүл үсэг, тоо хосолсон хэлбэрээр илэрхийлсэн дугаарыг; | - Стандарт боловсруулах |
| 4.3.Энэ хуулийн 4.2.2-т заасан тусгай хэрэглээний шуудангийн журмыг Засгийн газар, 4.2.3-т заасан дотоодын хэрэглээний шуудангийн журмыг Харилцаа холбооны зохицуулах хороо тус тус баталж мөрдүүлнэ. | - Журам боловсруулах, батлах<br>- Хяналт тавих |
| 7.1.8.Олон улсын шуудангийн байгууллагад Монгол улсыг төлөөлөх, олон улсын болон бүсийн хуралд бэлтгэх, оролцохтой холбогдсон болон олон улсын гишүүн орнуудаас урьдчилан гаргасан санал, дүгнэлт, судалгааны үр дүнг судлах ажлыг зохион байгуулах. | - Судалгаа хийх, санал боловсруулах<br>- Хуралд бэлтгэх, хуралд оролцох |
| 9.1.1.шуудангийн үйлчилгээний давуу эрхийн бүсийг тогтоох | - Зах зээлийн судалгаа хийх<br>- Шийдвэр гаргах |
| 9.1.2.энэ хуулийн 9.1.1-д заасан давуу эрхийн бүсэд шуудангийн үйлчилгээ үзүүлэгч бусад үйлчлэгчээс Харилцаа холбооны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан шуудангийн бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоож, журам батлах мөрдүүлэх; | - Журам боловсруулах, батлах<br>- Хяналт тавих |
| 9.1.4хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, түүнийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, зохицуулалтын баримт бичгийг баталж, биелэлтэд хяналт тавих, гэрээ байгуулах | - Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацааг сунгах, нэмэлт, өөрчлөлт оруулах, сэргээх үйл ажиллагаа<br>- Нөхцөл шаардлага боловсруулах<br>- Биелэлтэд хяналт тавих |
| 9.1.5.шуудангийн харилцан холболтын журмыг баталж, хэрэгжилтийг хангуулах; | - Журам боловсруулах, батлах<br>- Хэрэгжилтийг хангуулах |

| | |
|---|---|
| 9.1.6.шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх; | - Хугацааг тогтоосон тогтоол батлах<br>- Хяналт тавих |

**Хоёрдугаар үе шат:** Үүрэг буюу ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох.

Хуулийн заалт бүрийг гүйцэтгэх үүргээр нь задлан, үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагааг алхам тус бүрээр гарган түүнд зарцуулах хугацааг тодорхойлов (Хавсралт 4.1, 4.2, 4.3 ба 4.4).

Зохицуулалтын баримт бичиг боловсруулах ажил, үйлчилгээ нэг бүрийг хуулийн төсөл батлагдсаны дараа хамгийн багадаа жилд 1 удаагийн давтамжтай хийнэ гэж тооцов. Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг гаргав.

Хүснэгт 12. Зохицуулах байгууллагаас гарах зардлын тооцоо

| Хуулийн заалтын дугаар | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Нэгж зардал | Тоо | Дүн /төг/ | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 3.1.4 | Стандарт шинэчлэн боловсруулах | 803,685 | 1 | **803,685** | Хавсралт 4.3 |
| 3.1.5 | Стандарт шинэчлэн боловсруулах | 803,685 | 1 | **803,685** | |
| 3.1.8 | Стандарт шинэчлэн боловсруулах | 803,685 | 1 | **803,685** | |
| 3.1.10 | Стандарт шинэчлэн боловсруулах | 803,685 | 1 | **803,685** | |
| 4.3 | Журам боловсруулах, батлах | 850,705 | 1 | **850,705** | Уг заалтын найруулгыг өөрчилсөн бөгөөд одоо мөрдөж байгаа тул зардал нэмэгдэхгүй. |
| | Хяналт тавих | 723,978 | 1 | **723,978** | |
| 7.1.8 | Судалгаа хийх, санал боловсруулах | 465,050 | 1 | **465,050** | Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэн одоо хийгдэж байгаа ажлуудыг илүү |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | нарийвчлан заасан. |
| | Хуралд бэлтгэх, хуралд оролцох | - | - | - | Олон улсын хуралд 4 жилд нэг удаа, Ази номхон далайн бүсийн хуралд 2 жилд 1 удаа оролцдог тул тухайн үед зардал бодогдоно. |
| 9.1.1 | Зах зээлийн судалгаа хийх, шийдвэр гаргах | 850,705 | 1 | **850,705** | Хавсралт 4.2 болон 4.4 |
| | Хэрэгжилтэд нь хяналт тавих | 723,978 | 1 | **723,978** | |
| 9.1.2 | Журам боловсруулах, батлах; | 850,705 | 1 | **850,705** | Хавсралт 4.2 болон 4.4 |
| | Хэрэгжилтэд нь хяналт тавих; | 723,978 | 1 | **723,978** | |
| 9.1.4 | Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацааг сунгах, нэмэлт, өөрчлөлт оруулах, сэргээх үйл ажиллагаа | 3,481,725 | 9 | **31,335,525** | Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэн одоо хийгдэж байгаа ажлуудыг илүү нарийвчлан заасан. |
| | Нөхцөл шаардлага боловсруулах | 850,705 | 1 | **850,705** | Хавсралт 4.2 болон 4.4 |
| | Биелэлтэд хяналт тавих | 723,978 | 19 | **13,755,582** | |
| 9.1.5 | Журам боловсруулах, батлах; | 850,705 | 1 | **850,705** | Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэн одоо хийгдэж байгаа |
| | Хэрэгжилтийг хангуулах | 723,978 | 1 | **723,978** | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | ажлуудыг илүү нарийвчлан заасан. |
| 9.1.6 | Хугацааг тогтоосон тогтоол батлах | 850,705 | 1 | **850,705** | Хавсралт 4.2 |
| | Хяналт тавих | - | - | - | Бүртгэл хяналтын системээр байнгын хяналт тавьдаг тул зардал нэмж тооцогдохгүй. |
| | **Нийт гарах зардал** | | | **56,771,039** | |

Харилцаа холбооны зохицуулах хорооны албан хаагчдын 1 сарын дундаж цалин нь 1,383,360 төгрөг бөгөөд ажлын өдрийг 22 гэж тооцвол нэг минутад ноогдох ажлын хөлс нь 131 төгрөг болно.

**Гуравдугаар үе шат:** Зардлын тооцоог хүний нөөцийн, материаллаг, бусад гэсэн зардлын бүрэлдэхүүнд хувааж, тэдгээрийн нийлбэрийг гаргасны үндсэн дээр тогтооно.

Материаллаг зардлыг нэгдсэн байдлаар Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцоо хамруулсан болно.

**Дөрөвдүгээр үе шат:** Нийт дүнг тооцоолох бөгөөд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардлын нийлбэрээр нийт зардлыг тооцон гаргана.

**Нийт зардал = 56,771,039 төгрөг**

**Тавдугаар үе шат:** Хялбарчлах боломжийг шалгахдаа өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах, дарамт, ачааллыг багасгах арга замыг асуултад хариу авах замаар тодорхойлно:

Хүснэгт 13. Зохицуулах байгууллагын үүргийг хялбарчлах боломжийн асуулга

| Д/д | Асуулт | Хариулт | Тайлбар |
|---|---|---|---|
| 1. | Боловсруулан, батлах журмын тоог багасгах | Боломжгүй | Хуулиар үүрэгжүүлсэн. |
| 2. | Судалгааны мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх | Боломжгүй | Судалгаа ач холбогдолгүй болно. |

| | | | |
|---|---|---|---|
| 3. | Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх | Боломжтой | Өмнө нь хийгдэж байсан ажлууд бөгөөд Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэн дэлгэрэнгүй байдлаар хуульчилсан. |
| 4. | Зарим баримт бичгийг боловсруулах хугацааг багасгах боломжтой эсэх | Боломжтой | |
| 5. | Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх | Боломжгүй | Мэдээллийн хүртээмж буурна. |

**Дүгнэлт:**

Шуудангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5, 3.1.8 болон 3.1.10, 4 дугаар зүйлийн 4.3, 7 дугаар зүйлийн 7.1.8, мөн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2, 9.1.4, 9.1.5 болон 9.1.6 дахь заалтуудыг хэрэгжүүлэхэд нийт **56,771,039** (тавин зургаан сая зургаан зуун далан долоон мянга нэг зуун гучин ес) төгрөгийн зардал гарахаар тооцов.

Дээрх зардал тооцогдсон хуулийн заалтын хүрээнд хийгддэг ажил, үйлчилгээ нь одоогийн Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүргийн хүрээнд хийгддэг бөгөөд Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэх зорилгоор илүү нарийвчлан хуульчилсан юм. Иймд хүснэгт 12-т харуулсан тооцоогоор гарсан зардал нь одоо мөрдөж байгаа зардалд багтах учраас улсын төсөвт нэмэлт зардал үүсгэхгүй болно.

## НЭГДСЭН ДҮГНЭЛТ:

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалд заасны дагуу хэмжигдэхүйц зардлыг тооцсон болно. Үүнд:

1. Хуулийн этгээдийн зардлыг тооцохдоо дээр дурдсан аргачлалд хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг гэдгийг тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг ойлгохоор тусгажээ. /Үүнд бүх төрлийн өргөдөл, хүсэлт, маягт бөглөх, статистик тоо мэдээ өгөх, бүртгүүлэх, нөхөн олговор, төрөөс тусламж, дэмжлэг, зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл гаргах, зөвшөөрөл хүсэх гэх мэт үүрэг хамаарна./

Энэ хүрээнд хуулийн төслийн дүгээр зүйлийн 14.1, 16.3.3 дахь заалтад зардлын тооцоо хийсэн бөгөөд хуулийн этгээдээс нийт **7,992,950** (долоон сая есөн зуун ерэн хоёр мянга есөн зуун тавь) төгрөгийн зардал гарахаар тооцов.

2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын хариуцах чиг үүргийн хүрээнд дараах хуулийн заалтуудтай холбоотой гарах зардлыг тооцохдоо аргачлалын 4.3.3-т заасан ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг тооцохоор тусгасан тул хуулийн төслийн 6.1.4, 6.1.5, 7.1.1, 7.1.3, 7.1.5, 7.1.8 заалтуудад заасан ажиллагааг хэрэгжүүлэх зардлыг тооцоход нийт **4,809,945** төгрөгийн зардал гарахаар байна.

3. Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүргийн хүрээнд дараах хуулийн заалтуудтай холбоотой гарах зардлыг тооцохдоо аргачлалын 4.3.3-т заасан ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг тооцохоор тусгасан тул хуулийн төслийн 3.1.4, 3.1.5, 3.1.8, 3.1.10, 4.3, 7.1.8, 9.1.1, 9.1.2, 9.1.4, 9.1.5, 9.1.6 дахь заалтууд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардлыг тооцож нийт **56,771,039** төгрөгийн зардал гарахаар байна.

Шуудангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг **69,573,934** (жаран есөн сая таван зуун далан гурван мянга есөн зуун гучин дөрөв) төгрөгийн зардал гарахаар тооцов.

---o0o---

# ХАВСРАЛТ

Хавсралт 1

## ШУУДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖ БУЙ ХУУЛИЙН ЗААЛТ

| д/д | Зардал тооцогдох хуулийн заалт | Хариуцах байгууллагын нэрс | д/д | Зардал тооцогдохгүй хуулийн заалт | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | 3.1.4. "захидал" гэж тодорхой этгээдэд хаягласан, дугтуйлсан болон дугтуйлаагүй гар бичмэл, хэвлэмэл баримт бичиг агуулсан шуудангийн илгээмжийг; | ХХЗХ | 1 | 2.1. Шуудангийн тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, Харилцаа холбооны тухай хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. | Бусад хуультай нийцүүлсэн |
| 2 | 3.1.5. "боодол" гэж тодорхой этгээдэд хаягласан, эд зүйлс агуулсан битүүмжлэгдсэн шуудангийн илгээмжийг; | | 2 | 3.1.7. "үйлчлэгч" гэж шуудангийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээдийг /цаашид "үйлчлэгч" гэх/; | Найруулгын өөрчлөлт |
| 3 | 3.1.8 "шуудангийн хайрцаг" гэж шуудангийн илгээмжийг цуглуулах, хүргэхэд ашиглах зориулалтаар тодорхой цэгт байрлуулсан хэрэгслийг; | | 3 | 3.1.11. "шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч" гэж шуудангийн бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэгч байгууллагыг. | |
| 4 | 3.1.10. "шуудангийн нэгдсэн код" гэж үйлчлүүлэгчийн байршлыг тодорхойлсон тоо болон үсэг, тооны хосолсон илэрхийллийг; | | 4 | 3.1.12 "шуудангийн үндсэн сүлжээ" гэж төрийн өмчийн оролцоотой, бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэгчийн шуудангийн сүлжээг. | Шинэ нэр томъёо |
| 5 | 4.3. Энэ хуулийн 4.2.2-т заасан тусгай хэрэглээний шуудангийн журмыг Засгийн газар, 4.2.3-т заасан дотоодын хэрэглээний шуудангийн журмыг Харилцаа холбооны зохицуулах хороо тус тус баталж мөрдүүлнэ. | Засгийн газар ХХЗХ | 5 | 3.1.13 "Шуудангийн үйлчилгээ" гэж үйлчлүүлэгчээс шуудангийн илгээмж хүлээн авч шуудангийн сүлжээгээр дамжуулан хаягт эзэнд хүргэх нэгдмэл үйл ажиллагааг | |
| 6 | 6.1.4. шуудангийн нэгдсэн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журмыг батлах; | Засгийн газар ХХМТГ | 6 | 3.1.14. "үйлчлүүлэгч" гэж шуудангийн бүх төрлийн үйлчилгээг авч байгаа иргэн, хуулийн этгээдийг. | |
| 7 | 6.1.5. Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийг сонгох, гэрээ байгуулах, хяналт тавих журам батлах | | 7 | 4 дүгээр зүйл. Шуудангийн төрөл | Нэрний өөрчлөлт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | 7.1.1. бүх нийтийн үйлчилгээний төрлийг Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн тогтоох; | ХХЗХ ХХМТГ | 8 | 4.1. Монгол Улсын шуудан нь нийт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шуудангийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй бөгөөд түүнийг шуудангаар үйлчлэгч этгээд /цаашид "үйлчлэгч" гэх/ эрхлэн явуулна. | Хүчингүй болгосон заалт |
| 9 | 7.1.3. үйлчлэгч болон шуудангийн илгээмж тээвэрлэгч этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах журам боловсруулж хэрэгжүүлэх; | ХХМТГ | 9 | 5.1.7. шуудангийн сүлжээний ажиллагаа аюулгүй, тогтвортой байх | Найруулгын өөрчлөлт |
| 10 | 7.1.5.шуудангийн үнэт цаас, маркийг үйлдвэрлэх бодлого боловсруулах, шуудангийн үнэт цаас, маркны улсын фондыг баяжуулах, хадгалах, хамгаалах, хяналт тавих журам батлах; | | 10 | 6.1.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. | Дугаарын өөрчлөлт |
| 11 | 7.1.8. Олон улсын шуудангийн байгууллагад Монгол улсыг төлөөлөх, олон улсын болон бусийн хуралд бэлтгэх, оролцохтой холбогдсон болон олон улсын гишүүн орнуудаас урьдчилан гаргасан санал, дүгнэлт, судалгааны үр дүнг судлах ажлыг зохион байгуулах. | ХХМТГ ХХЗХ | 11 | 7 дугаар зүйл. Шуудангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх | Чиг үүргийг тодорхойлсон |
| 12 | 9.1.1. шуудангийн үйлчилгээний давуу эрхийг бусийг тогтоох | ХХЗХ | 12 | 7.1. Шуудангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: | |
| 13 | 9.1.2. энэ хуулийн 9.1.1-д заасан давуу эрхийн бусэд шуудангийн үйлчилгээ үзүүлэгч бусад үйлчлэгчээс Харилцаа холбооны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан шуудангийн бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоож, журам батлах мөрдүүлэх; | ХХЗХ | 13 | 7.1.9.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. | Дугаарын өөрчлөлт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 14 | 9.1.4 хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, түүнийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, зохицуулалтын баримт бичгийг баталж, биелэлтэд хяналт тавих, гэрээ байгуулах | ХХЗХ | 14 | 8.1.1 хүн амд шуудан, хэвлэл хүргэх ажлыг зохион байгуулах, цаг үеийн болон байнгын саад бэрхшээл бүхий газарт байрладаг үйлчлүүлэгчид шуудангийн илгээмж хүргэхэд үйлчлэгчид дэмжлэг үзүүлэх | Бусад хуультай нийцүүлсэн |
| 15 | 9.1.5. шуудангийн харилцан холболтын журмыг баталж, хэрэгжилтийг хангуулах; | ХХЗХ | 15 | 9.1.7.хууль тогтоомжид заасан бусад эрх хэмжээ. | Дугаарын өөрчлөлт |
| 16 | 9.1.6. шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх; | ХХЗХ | 16 | 10.2.1. аймаг, нийслэл, хот хооронд шуудангийн илгээмж хүргэх хуваарь, чиглэлийг шуудангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага; | Чиг үүргийг тодорхойлсон |
| 17 | 14.1. Үйлчлэгч нь Зохицуулах хорооноос баталсан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын дагуу захиалгат илгээмжийн худалдаа эрхэлж болно. | ХХЗХ Үйлчилгээ эрхлэгчид | 17 | 10.2.2. үйлчлэгчийн боловсруулсан аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг болон хот, тосгоны доторх шуудангийн илгээмж хүргэх хуваарь, чиглэлийг тухайн шатны Засаг дарга. | Бусад хуультай нийцүүлсэн |
| 18 | 16.3.3. шуудангийн үйлчилгээ үзүүлэхээр тогтоосон хугацаа, чанар нь үндэсний стандартыг хангаж буй тухай мэдээллийг үйлчлүүлэгчид гаргаж өгөх буюу мэдээлэх; | ХХЗХ Үйлчилгээ эрхлэгчид | 18 | 11 дүгээр зүйл. Шуудангийн сүлжээний ашиглалт | Нэрний өөрчлөлт |
| | | | 19 | 12.1. Шуудангийн бүх нийтийн үйлчилгээнд үйлчлэгч нь байршил, хүргэх боломжоос үл хамааран Монгол Улсын нутаг дэвсгэр дэх нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллагад шуудангийн илгээмжийг энэ хуулийн 9.1.6-т заасны дагуу тогтоосон хугацаанд хүргэх үйлчилгээ хамаарна. | Найруулгын өөрчлөлт |
| | | | 20 | 13 дугаар зүйл. Цахим шуудангийн үйлчилгээ | |
| | | | 21 | 13.1. Үйлчлэгч нь цахим шуудангийн үйлчилгээ эрхэлж болно. | |
| | | | 22 | 13.2. Цахим шуудангийн үйлчилгээнд шуудангийн сүлжээгээр дамжуулан факс, нийтийн цахим шуудан, цахим худалдаа, цахим баримт бичиг хүргэх зэрэг үйлчилгээ хамаарна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 23 | 15.2. Шуудангийн хэрэгсэл нь төрийн болон аймаг, нийслэл, сум, дүүрэг, иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байж болно. | Бусад хуультай нийцүүлсэн |
| | | | 24 | 16.3.6. хууль, гэрээгээр хүлээсэн бусад үүрэг | Дугаарын өөрчлөлт |
| | | | 25 | 16.3.5. Өөрийн сүлжээг бусад үйлчлэгч холбогдоход нээлттэй байлгах; | Шинэ заалт |
| | | | 26 | 16.5. Ажил үүргээ гүйцэтгэж яваа энэ хуулийн 16.1, 171.1-д заасан үйлчлэгч байгууллагын ажилтан нь үйлчлүүлэгчийн нутаг дэвсгэрт болон бүх төрлийн тээврийн буудал, орон нутгийн замын пост, гүүр, зогсоолд аливаа төлбөр, хураамжгүйгээр саадгүй нэвтрэх эрхтэй. | Найруулгын өөрчлөлт |
| | | | 27 | 171.1.2. шуудангийн үндсэн сүлжээ, түүний хэрэгсэл, бусад эд хөрөнгийг эзэмших, ашиглах, зохих журмын дагуу ижил нөхцлөөр бусад үйлчлэгчдэд түрээслүүлэх. | Найруулгын өөрчлөлт |
| | | | 28 | 171.2.3.Монгол Улсын олон улсын гэрээний хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцах. | Шинэ заалт |
| | | | 29 | ЗУРГАДУГААР БҮЛЭГ Шуудангийн илгээмжийн төрөл, зэрэглэл | Нэрний өөрчлөлт |
| | | | 30 | 19 дүгээр зүйл. Шуудангийн илгээмжийн төрөл, зэрэглэл | |
| | | | 31 | 19.2.Шуудангийн илгээмжийг хүргэх хугацаагаар нь ердийн, буухиа гэж зэрэглэнэ. | Найруулгын өөрчлөлт |
| | | | 32 | 20 дугаар зүйл. Шуудангийн илгээмжийн зэрэглэл | Хүчингүй болгосон заалт |
| | | | 33 | 20.1. Шуудангийн илгээмжийг хүргэх хугацаагаар нь ердийн, шуурхай, буухиа гэж зэрэглэнэ. | |
| | | | 34 | 20.2. Ердийн зэрэглэлийн илгээмжийг хотын дотор 2 хоног, аймаг, хотуудын хооронд 5 хоног, бусад газарт 12 хоногийн дотор хүргэсэн байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 35 | 20.3. Шуурхай зэрэглэлийн илгээмжийг хотын дотор 1 хоног, аймаг, хотуудын хооронд 3 хоног, бусад газарт 10 хоногийн дотор хүргэсэн байна. | |
| | | | 36 | 20.4. Буухиа зэрэглэлийн илгээмжийг хүргэх хугацаа нь гэрээнд зааснаар тодорхойлогдох бөгөөд энэ хуулийн 20.3-т заасан хугацаанаас богино байна. | |
| | | | 37 | 21.1.Улс хоорондын агаарын болон газрын шуудангийн илгээмжтэй холбоотой үйл ажиллагаанд Монгол Улсын олон улсын гэрээ болон үйлчлэгч хоорондын гэрээ, холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. | Бусад хуультай нийцүүлсэн |
| | | | 38 | 21.2.Улс хоорондын шуудангийн илгээмжид улс хоорондын шуудангийн сүлжээгээр дамжин хилийн чанадаас Монгол Улсын нутаг дэвсгэрт хүргэгдэж байгаа, Монгол Улсаас хилийн чанадад илгээж байгаа, эсхүл дамжин өнгөрч байгаа шуудангийн илгээмж хамаарна. | |
| | | | 39 | 23.4. Энэ хуулийн 23.2 - 23.3-т заасан үйл ажиллагаа явуулсан боловч хаягт эзнийг тогтоох боломжгүй болсон тохиолдолд илгээмжийг холбогдох байгууллагад шилжүүлэх буюу энэ хуулийн 7.1.7-д заасан журмын дагуу устгана. | Найруулгын өөрчлөлт |
| | | | 40 | 24.1.1 Галт зэвсгийн тухай хуулийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.1.6-д заасан галт зэвсэг болон түүнтэй адилтгах хэрэгсэл, Химийн хортой болон аюултай бодисын тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан химийн хорт болон аюултай бодис, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэл | Бусад хуультай нийцүүлсэн |
| | | | 41 | 24.1.3 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эхргэлтэд хяналт тавих тухай хуулийн 3.1.1, 3.1.4-д заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис болон түүхий эд | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 42 | 24.1.4. хуульд өөрөөр заагаагүй бол үндэсний болон гадаад валют; | |
| | | | 43 | 25.2.Шуудангийн марк нь Монгол Улсын тусгаар тогтнолыг илэрхийлсэн, шуудангийн илгээмжийн төлбөр төлөгдсөнийг баталгаажуулсан шуудангийн үнэт цаас болно. | Бусад хуультай нийцүүлсэн. |
| | | | 44 | 25.3. Шуудангийн маркийн хадгалалт, хамгаалалт, хөгжилд зарцуулах санг үүсгэх ба сангийн удирдлага, зохион байгуулалтыг төрийн захиргааны байгууллага хариуцна. | Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн хариуцах эзнийг тодорхойлсон. |

Хавсралт 2

## ЖУРАМ БАТЛАХАД ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

| Хэрэгжүүлэх байгууллага | Гүйцэтгэх үүрэг | Стандарт үйл ажиллагаа | Хугацаа /мин/ | Тохиолдлын тоо | Хүний нөөцийн хэрэгцээ /мин/ |
|---|---|---|---|---|---|
| Засгийн газрын Хэрэг эрхлэх газар | Журам батлах | Баримт бичгийн төсөлтэй танилцах, судлах | 240 | 1 | 240 |
| | | Шийдвэрийн томьёоллыг бэлтгэх | 120 | 1 | 120 |
| | | Баримт бичгийн төслийг танилцуулах | 150 | 1 | 150 |
| | | Төсөлд яамдаас санал авах /нэг яамнаас санал авах хугацааг 240 мин гэж тооцон 15 яамнаас авахаар тооцов/ | 240 | 15 | 3600 |
| | | Яамдаас ирүүлсэн саналыг төсөлд тусгах эсэхийг хэлэлцэх | 90 | 10 | 900 |
| | | Хуралдааны бэлтгэл хангах | 180 | 1 | 180 |
| | | ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх | 60 | 1 | 60 |
| | | ЗГ-ын тогтоолыг ёсчлох | 90 | 1 | 90 |
| | | Шийдвэрийг хүргүүлэх | 20 | 1 | 20 |
| | | Тогтоолыг нийтлэх | 40 | 1 | 40 |
| | | **Нийт** | **1230** | | **5400** |
| Тайлбар: Нэг журам батлахад 5400 минут шаардагдах бөгөөд үүнийг ЗГХЭГ-ийн реферэнтийн ажлын хөлс 85 төгрөгөөр тооцоход 459000 төг. | | | | | |

Хавсралт 2.1

## ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ, ХУГАЦААГ СУНГУУЛАХ, БҮРТГҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

| Гүйцэтгэх үүрэг | Ажил, үйлчилгээ | Стандарт үйл ажиллагаа | Зарцуулах хугацаа /мин/ | Ажлын хөлс /төг/ | Зардал /төг/ |
|---|---|---|---|---|---|
| Тусгай зөвшөөрөлтэй байх | Үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах | Холбогдох мэргэжилтэнгээс мэдээлэл авах | 30 | 57 | 1710 |
| | | Өргөдөл бичих | 40 | 57 | 2280 |
| | | Маягт бөглөх | 60 | 57 | 3420 |
| | | Санхүүгийн болон техникийн чадавхийн талаарх баримт бичгүүд бүрдүүлэх | 1440 | 57 | 82080 |
